



МОНГОЛ УЛСЫН
ДЭЭД ШҮҮХ



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ БҮТЭН
ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2017 он



ГАРЧИГ

1. Илтгэгчийн үг: Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв	2-3
2. Улсын Дээд шүүхийн 2017 оны ажлын тайлангийн товч танилцуулга	4-5
3. Эрүүгийн хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан	6-10
4. Иргэний хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан	11-16
5. Захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажлын тайлан	17-21
6. Бусад асуудлаар	22-25
7. Тамгын газрын ажлын тайлан	26
8. Захиргаа удирдлагын хэлтсийн ажлын тайлан	27-31
9. Шүүхийн практик судлалын хэлтсийн ажлын тайлан	31-36
10. Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн ажлын тайлан	36-39
11. Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн ажлын тайлан	39-40
12. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн ажлын тайлан	40-41
13. Ерөнхий шүүгчийн ажлын албаны ажлын тайлан	42
14. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны ажлын тайлан	43-45
15. Дотоод аудитын албаны ажлын тайлан	45-48
16. Сургалт семинар	48-58



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч: Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв

Эрхэм хүндэт шүүгч, ажилтнуудаа!

Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Өнгөрч буй онд бид шүүхийн шинэтгэлийг амжилттай үргэлжлүүлж, шүүн таслах болон шүүхийн захиргааны ажлын талаар багагүй үр дүнд хүрч, түүнийгээ тайлагнах гэж буйд хувьдаа баяртай байна.

Энэ хугацаанд шүүх, шүүгчийн үндсэн хэрэглээ болсон салбарын суурь шинжтэй материаллаг болон процессын цөөнгүй хууль тогтоомж шинэчлэн найруулагдаж батлагдсан бөгөөд үүнд тус шүүхийн Танхимын тэргүүнүүд болон шүүгч, захиргааны ажилтнууд идэвхитэй ажиллаж, хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд болон шүүхээс хууль хэрэглэх асуудалд зарчмын өөрчлөлт, хүний эрх, эрх чөлөөг шүүхийн журмаар нөхөн сэргээх, баталгаажуулахад дэвшил гарсныг дурьдахад Таатай байна.

Дээрх хуулиудаас дурьдвал Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай гэх мэт хуулиудыг шинээр болон нэмэлт, өөрчлөлт орж баталлаа.

Одоо бидэнд эдгээр хуулиудын хэрэгжилтийг нэг мөр хэрэгжүүлэх бодлогын зорилтууд хүлээгдэж байна.

2017 онд шүүхийн гадаад харилцааг өргөжүүлэх, харилцан найрсаг хамтын ажиллагааг бэхжүүлэх, гадаадын зарим орнуудтай хамтран зохион байгуулж буй шүүгчдийн сургалтыг тогтмолжуулах, түүний үр нөлөөг дээшлүүлэх, тодорхой зарим арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлснээр БНХАУ, БНСУ, Испанийн сургалтууд тогтмолжихийн зэрэгцээ олон улсын гишүүнчлэл бүхий шүүх, бусад байгууллага, нэгдэлүүдтэй хамтран ажиллах эхлэлийг тавьлаа.

Түүнчлэн Улсын Дээд шүүхийн шүүгч **Ч.Хосбаяр** нь 2017 оны 3 дугаар сарын 07-ны өдөр Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн оролцогч улсуудын Ассамблейн ажлын албанаас зарласан шүүгчийн сонгон шалгаруулалтанд Монгол Улсаас анх удаа нэр дэвшиж, амжилттай оролцлоо.

Та бүхний энэхүү нөр их хөдөлмөрийг үнэлж 2017 онд Үндэсний их баяр наадам, Тулгар төр байгуулагдсаны **2226** жил, Их Монгол Улс байгуулагдсаны




811 жил, Ардын хувьсгалын **96** жил, Их эзэн Чингис хааны мэндэлсний **855** жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгч **Л.Атарцэцэгийг** Монгол Улсын “Гавъяат хуульч” цолоор, шүүгч **Ч.Хосбаярыг** “Хөдөлмөрийн гавъяаны Улаан туг”-ийн одонгоор, Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **Г.Алтанчимэг** нарыг “Алтангадас” одонгоор тус тус шагнагдсаныг дурьдахгүй байж болохгүй билээ.




УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Улсын Дээд шүүхийн нийт хүлээж авсан 3221 хэргээс:




Шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 2589 хэргээс:







Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн болон захиргааны хэргийн танхимуудын
2017 онд хүлээж авсан хэргийг өмнөх онтой харьцуулбал:



2017 онд шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийг өмнөх
онтой харьцуулбал:



Улсын Дээд шүүхийн нэг шүүгчид ногдох хэргийн ажлын ачааллыг өмнөх онтой
харьцуулбал:





ЭРҮҮГИЙН
ХЭРГИЙН
ТАНХИМ




НЭГ. ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Эрүүгийн хэргийн танхим.

Эрүүгийн хэргийн танхим 2016 оны үлдэгдэл 6 хэрэг дээр 2017 онд хяналтын шатны журмаар эрүүгийн 455, цагаатгалын 5, нийт 466 хэрэг хүлээн авч, эрүүгийн 340, цагаатгалын 2 буюу нийт 342 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 84 хэргийг албан бичгээр буцааж, 12 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, 28 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан эрүүгийн 466 хэргээс:



Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 75 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 4.6 хэрэг хэлэлцжээ.

Эрүүгийн хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн хэргээс нэг шүүгчид 75.6 хэрэг ногдож байна.

Хяналтын журмаар шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн 342 хэргийн 43.8 хувь буюу 150 хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, 35.1 хувь буюу 120 хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, 21.1 хувь буюу 72 хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгожээ.




Өөрчлөлт оруулсан **120** хэргийн **9.2** хувь буюу **11** хэргийг Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, **0.8** хувь буюу **1** хэргийг хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, **7.5** хувь буюу **9** хэргийг Эрүүгийн хуулийн 55¹¹, 62¹¹ дүгээр зүйлээр, **3.3** хувь буюу **4** хэргийг хуулийг жинхэнэ агуулгаас зөрүүтэй буруу ойлгож хэрэглэсэн, **79.2** хувь буюу **95** хэргийг бусад гэсэн үндэслэлүүдээр өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **72** хэргийн **31.9** хувь буюу **23** хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр **прокурорт**, **36.1** хувь буюу **26** хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, **2.8** хувь буюу **2** хэргийг (үүнээс 1.4 хувь буюу 1 нь цагаатгалын хэрэг) **хэрэгсэхгүй** болгож, **29.2** хувь буюу **21** хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгожээ.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн Б.Цогт **78**, шүүгч Д.Ганзориг **92**, Б.Батцэрэн **90**, Д.Эрдэнэбалсүрэн **88**, Ч.Хосбаяр **87**, С.Батдэлгэр **19**, Ерөнхий шүүгчийн ажлын алба **12** эрүүгийн хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн болон Ерөнхий шүүгчийн ажлын албаны хүлээн авсан хэрэг




Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Ерөнхий шүүгч Ц.Зориг **3**, Танхимын тэргүүн Б.Цогт **259**, Танхимын тэргүүн Т.Уранцэцэг **213**, шүүгч Д.Ганзориг **312**, Д.Эрдэнэбалсүрэн **304**, Б.Батцэрэн **303**, Ч.Хосбаяр **248**, С.Батдэлгэр **68** тус тус **оролцсоноос**;

Ерөнхий шүүгч Ц.Зориг **3**, Танхимын тэргүүн Б.Цогт **33**, Танхимын тэргүүн асан Т.Уранцэцэг **213**, шүүгч Б.Батцэрэн **80**, Д.Эрдэнэбалсүрэн **12**, Ч.Хосбаяр **1** хэргийн шүүх хуралдааныг даргалж;

Танхимын тэргүүн Б.Цогт **64**, шүүгч Д.Ганзориг **74**, Д.Эрдэнэбалсүрэн **69**, Б.Батцэрэн **62**, Ч.Хосбаяр **58**, С.Батдэлгэр **15** илтгэсэн байна.



Эрүүгийн хэргийн танхимын шүүгчдийн 2017 оны бүтэн жилийн ажлын ачаалал:



2017 онд цагаатгал хариуцсан шинжээчээс Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан **23** өргөдөл, хүсэлтийг хүлээн авч нийтдээ **20** цагаатгалын үнэмлэх олгосноос **11** үнэмлэх шинээр, **9** үнэмлэх нөхөн олгож, цагаатгалын үнэмлэх олгох боломжгүй талаар **3** өргөдөл, хүсэлтэд албан бичгээр хариу өгсөн байна.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн цагаатгалын **3** хүнд холбогдох **2** хэргийн **2** хүнд холбогдох **1** хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, тэднийг цагаатгаж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **94.2** хувь буюу **322** хэргийг ялтан, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн **гомдлоор**, **0.6** хувь буюу **2** хэргийг иргэний хариуцагчийн гомдлоор, **2.6** хувь буюу **9** хэргийг улсын яллагчийн **эсэргүүцлээр**, **2.6** хувь буюу **9** хэргийг прокурорын **дүгнэлтээр** хэлэлцэгджээ.

Тайлангийн хугацаанд Танхимын тэргүүн Б.Цогт **10**, шүүгч Б.Батцэрэн **22**, Ч.Хосбаяр **22**, Д.Эрдэнэбалсүрэн **14**, Д.Ганзориг **12**, С.Батдэлгэр **4**, нийт **84** хэргийг хянаж албан бичиг болон шүүгчийн захирамжаар буцаасан байна.

Эрүүгийн хэргийн танхим 2017 онд нийт **80** албан бичиг, **65** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Б.Цогт **15** албан бичиг, **2** өргөдөл



гомдол, Танхимын тэргүүн асан Т.Уранцэцэг **35** албан бичиг, **8** өргөдөл гомдол, шүүгч Б.Батцэрэн **1** албан бичиг, **5** өргөдөл гомдол, Д.Ганзориг **6** албан бичиг, **2** өргөдөл гомдол, Ч.Хосбаяр **1** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Д.Эрдэнэбалсүрэн **5** албан бичиг, **2** өргөдөл гомдол, С.Батдэлгэр **15** албан бичиг, **43** өргөдөл гомдол тус тус хянан шийдвэрлэж, одоо Танхимын тэргүүн Б.Цогт **2** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч Б.Батцэрэн **1** өргөдөл гомдлын үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний захирамж **532**, шүүхийн тогтоол **67**, мэдэгдэх хуудас **114** гарсан байна.




ИРГЭНИЙ
ХЭРГИЙН
ТАНХИМ



1.2. Иргэний хэргийн танхим

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **56** хэрэг дээр хяналтын шатны журмаар **1879**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **56**, нийт **1991** хэрэг хүлээн авч, **1704** хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **56** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар хэлэлцэж, **49** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж, **20** хэргийн харьяаллыг тогтоосон байна. Иргэний хэргийн танхим үлдэгдэл **162** хэрэгтэй байна.

Нийт хүлээн авсан 1991 хэргээс:



Иргэний хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **98** өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар **18** хэрэг хэлэлцжээ.

Иргэний хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **1704** хэргээс нэг шүүгчид **243** хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн иргэний **1704** хэргийн **53.7** хувь буюу **915** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **11.5** хувь буюу **196** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, **18** хувь буюу **307** хэргийн шийдвэр, магадлалд нэмэлт, өөрчлөлт оруулж, **11.2** хувь буюу **191** хэргийн магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилж, **5.6** хувь буюу **95**




хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Өөрчлөлт оруулсан **307** шийдвэр, магадлалын **75.6** хувь буюу **232** нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хууль хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, **24.4** хувь буюу **75** нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийн дахин хэлэлцүүлэхээр буцаасан **196** хэргийн **47.4** хувь буюу **93** хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, **52.6** хувь буюу **103** хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ. Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон **95** хэргийн **61** хувь буюу **58** нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, **39** хувь буюу **37** нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна.

Хяналтын журмаар Шүүгч Ц.Амарсайхан **294**, Г.Алтанчимэг **293**, Г.Цагаанцоож **293**, Б.Ундрах **292**, П.Золзаяа **288**, Х.Эрдэнэсүвд **271**, Д.Цолмон **184** хэрэг хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг:






Хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанд шүүгч Х.Эрдэнэсүвд **864**, Г.Алтанчимэг **853**, Г.Цагаанцоож **817**, Ц.Амарсайхан **746**, П.Золзаяа **735**, Б.Ундрах **702**, Д.Цолмон **426** удаа **оролцсоноос**;

Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **1456**, шүүгч Г.Цагаанцоож **112**, П.Золзаяа **36**, Ц.Амарсайхан **52**, Б.Ундрах **42**, Г.Алтанчимэг **4**, Х.Эрдэнэсүвд **2** хуралдааныг тус тус **даргалж**;

Шүүгч Г.Цагаанцоож **261**, Г.Алтанчимэг **259**, Б.Ундрах **259**, Х.Эрдэнэсүвд **259**, Ц.Амарсайхан **257**, П.Золзаяа **253**, Д.Цолмон **156** хэргийг **илтгэсэн** байна.

Иргэний хэргийн танхимын шүүгчдийн 2017 оны бүтэн жилийн ажлын ачаалал



Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **741** нэхэмжлэгчийн, **953** хариуцагчийн, **10** гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **1704** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Иргэний хуулиар **1104**, Хөдөлмөрийн тухай хуулиар **392**, Гэр бүлийн тухай хуулиар **47**, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар **123**, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар **8**, бусад хуулиар **30** хэргийг хянан шийдвэрлэжээ.



Мөн энэ хугацаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **1041946694** /тэр бум дөчин нэгэн сая есөн зуун дөчин зургаан мянга зургаан зуун ерэн дөрөв/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **547894715** /таван зуун дөчин долоон сая найман зуун ерэн дөрвөн мянга долоон зуун арван тав/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим **2017** онд нийт **83** албан бичиг, **51** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Х.Сонинбаяр **49** албан бичиг, **18** өргөдөл, гомдол, шүүгч Д.Цолмон **9** албан бичиг, **5** өргөдөл, гомдол, Г.Цагаанцоож **7** албан бичиг, **3** өргөдөл, гомдол, Х.Эрдэнэсүвд **6** албан бичиг, **2** өргөдөл гомдол, Г.Алтанчимэг **4** албан бичиг, **8** өргөдөл гомдол, П.Золзаяа **3** албан бичиг, **4** өргөдөл, гомдол, Ц.Амарсайхан **1** албан бичиг, **3** өргөдөл, гомдол, Б.Ундрах **1** албан бичиг, **7** өргөдөл, гомдол тус тус хянан шийдвэрлэж, одоо **3** албан бичиг, **1** өргөдөл, гомдлын үлдэгдэлтэй байна.

Иргэний хэргийн танхим 2017 оны бүтэн жилийн байдлаар Улс төрийн намын бүртгэлийн талаар дараах ажлыг хийжээ. Үүнд:

- Зон Олны намыг 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд шинээр бүртгэхээс татгалзаж;
- Ардчилсан намын дүрэм, журмын өөрчлөлтийг 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор бүртгэхээс татгалзаж;
- Монголын Хүний төлөө намыг 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд шинээр бүртгэж;
- Ардчилсан намын дүрмийн өөрчлөлтийг 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 05 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Тусгаар тогтнол, Эв нэгдлийн намын дүрмийн болон даргын өөрчлөлтийг 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 06 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж;
- Хөдөлмөрийн үндэсний намын дүрмийн болон даргын өөрчлөлтийг 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж,
- Үнэн ба Зөв намыг 2017 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 08 дугаар тогтоолоор улсын бүртгэж шийдвэрлэсэн байна.
- Гэр хороолол хөгжлийн намыг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор бүртгэхээс татгалзаж,
- Зон Олны намыг 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж,



- Зон Олны намын даргын өөрчлөлтийг 2017 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж,
- Монгол Ардын намын дүрмийн өөрчлөлтийг 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 13 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Монголын Үндэсний Ардчилсан намын даргын өөрчлөлтийг 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж,
- Гэр Хороолол Хөгжил намыг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Монгол Ардын хувьсгалт намын дүрмийн өөрчлөлтийг 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 17 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж,
- Эх орон намын даргын өөрчлөлтийг 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 18 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж,
- Монгол Ардын намын дүрмийн болон даргын өөрчлөлтийг 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор улсын бүртгэлд бүртгэж шийдвэрлэсэн байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **2422** гаргаснаас Танхимын тэргүүний “Шүүх бүрэлдэхүүн томилох тухай” **1852**, “Улсын тэмдэгтийн хураамж буцааж олгох тухай” **521**, “Гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” **15**, “Гомдол гаргаагүйд тооцох тухай” **34** шүүгчийн захирамж тус тус гарчээ.




ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН
ТАНХИМ



1.3. Захиргааны хэргийн танхим

Захиргааны хэргийн танхимын өмнөх оны үлдэгдэл **13** хэрэг /хяналтын журмаар гомдол гаргасан **9**, Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлт **1**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **3** хэрэг/ дээр **2017** онд хяналтын шатны журмаар **579** захиргааны хэрэг, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **77**, шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар **38**, Шүүхийн ёс зүйн хорооны гомдолтой **16**, Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны тогтоолтой **6**, Анхан шатны журмаар **2** нэхэмжлэл, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэртэй **3**, гомдлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргасан **30** нийт **764** хэрэг хүлээн авч, **543** хэргийг хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар, **62** хэргийг хуралдаанд оролцуулахгүйгээр, гомдлыг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргасан **30** хэргийг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **37** хүсэлтийг шийдвэрлэж, **74** хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанаас хариу өгч, одоо **18** хэргийн /хяналтын журмаар гомдол гаргасан **8**, анхан шатны журмаар хэлэлцэх **2**, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах **2**, ерөнхий шүүгчийн ажлын алба **6**/ үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авсан 764 хэргээс:





Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **63** өдөр хуралдаж, **өдөрт** дунджаар **8.6** хэрэг хэлэлцжээ.

Захиргааны хэргийн танхимд хяналтын шатны журмаар ирүүлсэн **684** хэргээс нэг шүүгчид **97.7** хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын шатны журмаар хэлэлцэгдсэн **543** хэргийн **63.4** хувь буюу **344** хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **11.0** хувь буюу **60** хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, **25.6** хувь буюу **139** хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.


Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан **60** хэргийн **43.3** хувь буюу **26** хэргийг хууль буруу хэрэглэсэн, **38.4** хувь буюу **23** хэргийг шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **18.3** хувь буюу **11** шийдвэр, магадлалд бусад өөрчлөлт оруулсан.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон **139** хэргийн **28.8** хувь буюу **40** хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **31.7** хувь буюу **44** хэргийн хэргийг болон нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох, эсхүл нэхэмжлэлийг хангасан, **39.5** хувь буюу **55** хэргийн магадлал хүчингүй, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчлөлт оруулсан байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай **33** хэргийн хүсэлтийг хангаагүй, **3** хүсэлтийг хангасан, **1** хэргийн оролцогч хүсэлтээсээ татгалзсан байна.

Хяналтын журмаар шүүгч П.Соёл-Эрдэнэ **100**, Д.Мөнхтуяа **99**, Л.Атарцэцэг **98**, Х.Батсүрэн **98**, Г.Банзрагч **97**, Ч.Тунгалаг **96**, Б.Мөнхтуяа **96** захиргааны хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг:





Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд шүүгч П.Соёл-Эрдэнэ 263, Г.Банзрагч 256, Д.Мөнхтуяа 241, Б.Мөнхтуяа 229, Х.Батсүрэн 219, Ч.Тунгалаг 217, Л.Атарцэцэг 204 удаа тус тус оролцсоноос,

Танхимын тэргүүн М.Батсуурь 374, шүүгч Х.Батсүрэн 68, Л.Атарцэцэг 62, Ч.Тунгалаг 27, Д.Мөнхтуяа 12 хэргийн шүүх хуралдааныг тус тус даргалж;


Шүүгч П.Соёл-Эрдэнэ 82, Б.Мөнхтуяа 79, Г.Банзрагч 78, Ч.Тунгалаг 78, Л.Атарцэцэг 77, Д.Мөнхтуяа 77, Х.Батсүрэн 72 хэрэг тус тус илтгэсэн байна.

Гомдлыг хүлээн авахаас татгалзсан захирамж, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг шийдвэрлэх шүүх хуралдаанд шүүгч Д.Мөнхтуяа 27, Ч.Тунгалаг 21, Х.Батсүрэн 21, Б.Мөнхтуяа 20, Г.Банзрагч 19, П.Соёл-Эрдэнэ 17, Л.Атарцэцэг 16 удаа тус тус оролцсоноос,

Танхимын тэргүүн М.Батсуурь 34, шүүгч Х.Батсүрэн 15, Л.Атарцэцэг 10, П.Соёл-Эрдэнэ 4, Ч.Тунгалаг 2, Д.Мөнхтуяа 2 хэргийн шүүх хуралдааныг тус тус даргалж;

Шүүгч Д.Мөнхтуяа 11, Л.Атарцэцэг 10, Б.Мөнхтуяа 10, Г.Банзрагч 9, Х.Батсүрэн 9, Ч.Тунгалаг 9, П.Соёл-Эрдэнэ 9 хэрэг тус тус илтгэсэн байна.

Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн 2017 оны ажлын ачаалал:



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн нийт хэргийн 212 нь хэргийн оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн, 134 нь нэхэмжлэгчийн, 87 нь хариуцагчийн, 74 нь өмгөөлөгчийн, 36 нь гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.



Хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **543** хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

Төрийн албаны маргаан **156**;

Газрын маргаан **106**;

Ашигт малтмалын маргаан **66**;

Татварын маргаан **38**;

Сонгуулийн маргаан **35**;

Эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой маргаан **33**;

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан **13**;

Шүүхийн Ёс зүйн хорооны магадлалтай **13**;

Хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын хорооны тогтоолтой **5**, бусад маргаан **78** байна.

Мөн хугацаанд нэхэмжлэгч, гуравдагч этгээдээс хяналтын журмаар гаргасан гомдолд нийт **27,378,000** /Хорин долоон сая гурван зуун далан найман мянган/ төгрөгийг улсын тэмдэгтийн хураамжид төлсний **4,773,600** /дөрвөн сая долоон зуун далан гурван мянга зургаан зуун/ төгрөгийг буцаан олгожээ.

Тус танхим **2017** оны бүтэн жилд нийт **39** албан бичиг, **17** өргөдөл, гомдол хүлээн авснаас: Танхимын тэргүүн М.Батсуурь **28** албан бичиг, **10** өргөдөл гомдол, шүүгч Б.Мөнхтуяа **3** албан бичиг, шүүгч Г.Банзрагч **1** албан бичиг, **2** өргөдөл гомдол, шүүгч Д.Мөнхтуяа **2** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч П.Соёл-Эрдэнэ **2** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч Л.Атарцэцэг **1** албан бичиг, **1** өргөдөл гомдол, Х.Батсүрэн **1** албан бичиг, **1** өргөдөл гомдол, шүүгч Ч.Тунгалаг **1** албан бичиг, **1** өргөдөл гомдолд хариу өгсөн байна.

Тайлангийн хугацаанд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол **903** гаргаснаас “хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай” **548**, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” **152**, “улсын тэмдэгтийн хураамж буцаах тухай” захирамж **66**, “гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай” **60**, “шинээр илэрсэн нөхцөл байдлын хүсэлтийг шийдвэрлэх тухай” шүүхийн тогтоол **37**, Гомдол хүлээн авахаас татгалзсан захирамжийг хэлэлцсэн **30**, “хүсэлт гаргаагүйд тооцох тухай” **3**, “хялбаршуулсан журмаар” **5**, бусад **2** гарсан байна.



ХОЁР. БУСАД АСУУДЛААР

Улсын Дээд шүүхийн шүүгч нар:

- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”;
- “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”;
- “Зөрчлийн тухай” хууль;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай;
- “Арбитрын тухай” хууль;
- “Хөдөлмөрийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга;
- “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга;
- “Патентийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай;
- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга;
- “Шүүхийн ёс зүйн хорооны дүрэм”-ийн шинэчилсэн найруулга;
- “Шүүгчийн сонгон шалгаруулах журам”-ын төслүүдэд тус тус санал өгч, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үүргээ хэрэгжүүлжээ.

2017 онд бид дараах бүтээлийг эрхлэн хэвлүүлж, нийтийн хүртээл болголоо.
Тухайлбал:

- Өрсөлдөөний эрх зүй -2 гарын авлага;
- Захиргааны ерөнхий хуулийн тайлбар /судалгаа, хэрэглээний/;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн гарын авлага;
- Шүүх эрх мэдэл 2017 №1 “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг харьцуулсан эрх зүйн үүднээс авч үзэх нь” өгүүлэл;
- “Эрдэс баялагийн салбарын гэрээнд захиргааны ерөнхий хуулийн “сонсох ажиллагаа”-ны журмыг хэрэгжүүлэх нь”, Нээлттэй нийгэм форум, Бодлогын зөвлөмж, №24 2016 оны 12 сар;
- “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ” шүүмж өгүүлэл, МУИС, ХЗС, Эрх зүй сэтгүүл, 2016 оны №4;
- Ашигт малтмалын эрх зүй -2 гарын авлага;
- “Өмгөөлөгч” сэтгүүлд “Монголын эрх зүйн хөгжил ба шүүхийн шийдвэр” сэдэвт нийтлэл;
- Шүүгчдэд зориулсан “Оюуны өмчийн эрх зүй” 2 дахь гарын авлага;



- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан сургалтын гарын авлагад зориулж “Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хангах, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах” сэдэвт сургалтын хөтөлбөр;
- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан сургалтын гарын авлагад зориулж “Газрын маргааныг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал” сэдвээр сургалтын хөтөлбөр;
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4-12 дугаар зүйлийн /хэрэг хянан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим/ тайлбарын эхний төсөл;
- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан сургалтын гарын авлагад зориулж “Захиргааны гэрээний зохицуулалт” сэдэвт хичээлийн хөтөлбөр;
- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан сургалтын гарын авлагад зориулж “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хэргийн оролцогчийн эрх зүйн байдал” сэдвээр хичээлийн хөтөлбөр
- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан сургалтын гарын авлагад зориулж “Төрийн албаны маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн практик” сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулсан;
- Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан сургалтын гарын авлагад зориулж “Татварын маргааныг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал сэдвээр” сургалтын хөтөлбөр зэргийг боловсруулсан болно.

Мөн Иргэний хэргийн танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, шүүгч **Ц.Амарсайхан**, **Б.Ундрах**, **Г.Цагаанцоож** нар “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай” хуулийн шинэчилсэн найруулга, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр;

Танхимын тэргүүн **Х.Сонинбаяр** Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/ иргэний хэргийн мониторингийн ажлын хэсгийн ахлагчаар;

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “Хууль тайлбарлах онол арга зүй” хичээлийн хөтөлбөр, сэдэв боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар;

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс эрхлэн гаргадаг “Шүүх эрх мэдэл” мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхтгэлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр;

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** “Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийн ажлын хэсгийн ахлагчаар;

“Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-ийн ажлын хэсгийн гишүүнээр;

Хуульч, эдийн засагчийн нэгдсэн клубын гишүүнээр;



“Шүүх эрх мэдэл” мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхтгэлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр;

“Өмгөөлөл” сэтгүүлийн редакцийн гишүүнээр;

шүүгч **Г.Алтанчимэг** “Арбитрын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсгийн гишүүнээр;

шүүгч **Ц.Амарсайхан** “Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль”-ийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр;

“Шүүхийн сонгомол шийдвэр шалгаруулах” ажлын хэсгийн гишүүнээр;

шүүгч **С.Батдэлгэр** “Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга”, “Зөрчлийн тухай хууль”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-ийн төслүүдийн ажлын хэсгийн гишүүнээр;

шүүгч **Б.Батцэрэн** “Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийг хэрэгжүүлэх” ажлын хэсгийн ахлагчаар;

шүүгч **Б.Батцэрэн, Д.Мөнхтуяа** нар Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүнээр;

шүүгч **П.Золзаяа** “Арбитрын тухай хууль”-ийн болон Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн ажлын хэсгийн гишүүнээр;

шүүгч **Б.Мөнхтуяа** “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн ажлын хэсгийн гишүүнээр;

шүүгч **Д.Мөнхтуяа** Монголын шүүгчдийн холбооны Улсын Дээд шүүхийн шүүгчдийн холбооны салбар зөвлөлийн гишүүн, Монголын шүүгч эмэгтэйчүүдийн холбооны гишүүнээр;

шүүгч **Ч.Тунгалаг** Улсын Дээд шүүхээс нийтлэн гаргадаг “Монголын төр, эрх зүй” сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр;

шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн** Монголын Хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр,

шүүгч **Д.Цолмон** Хууль Зүй Дотоод хэргийн яам-Патент, барааны тэмдэг, зохиогчийн эрхийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсгийн гишүүнээр,

мөн Хууль Зүй Дотоод хэргийн яам-Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийн гишүүнээр,

шүүгч **Х.Эрдэнэсүвд** Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуультай холбогдуулан эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон сонгуулийн насны иргэдийн мэдээллийг Сонгуулийн тухай хуульд зааснаар зохих байгууллагад мэдээллэх ажлын хэсгийн ахлагчаар,



Танхимын тэргүүн **М.Батсуурь** Нотариатын тухай хуулийн ажлын хэсгийн гишүүнээр,

шүүгч **Л.Атарцэцэг** Шүүхийн тухай багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгын ажлын хэсгийн гишүүнээр;

шүүгч **Б.Мөнхтуяа** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх ажлын хэсгийн дэд хэсгийн бүрэлдэхүүнд тус тус ажилласан байна.

шүүгч **Г.Алтанчимэг** “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчим, иргэний хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа, цаашид анхаарах асуудал” сэдвээр;

шүүгч **Ц.Амарсайхан** “Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс ногдох хэсгийг тогтоож буй шүүхийн практикт анхаарах зарим асуудал” сэдвээр, шүүгч **П.Золзаяа** “Худалдах, худалдан авах гэрээнээс үүссэн маргааныг шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал” сэдвээр тус тус зөвлөмж гаргажээ.

шүүгч **Г.Цагаанцоож** “Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар 2016 онд хянагдсан хэргийн судалгаа, цаашид анхаарах зарим асуудлаар” тойм боловсруулж, холбогдох шүүх, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлжээ.

Мөн танхимын тэргүүн Х.Сонинбаяр МҮОНТ-ийн эфирээр гарсан 2017 оны 5 дугаар сарын 22-ны өдөр “Гэр бүл, хүүхдийн тэтгэлэг” сэдвээр Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Цолмонбаатарын ярилцлага, мөн сэдвээр хэвлэлийн хэлтсээс бэлдсэн зохиомж;

2017 оны 5 дугаар сарын 29-ний өдөр “Худалдах худалдан авах гэрээ, орон сууцны зөрүүтэй холбоотой маргааныг шийдвэрлэж буй шүүхийн практик” сэдвээр Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч С.Будын ярилцлага, мөн сэдвээр хэвлэлийн хэлтсээс бэлтгэсэн зохиомж;

2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр “Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдвээр Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Б.Нармандахын ярилцлага, мөн сэдвээр хэвлэлийн хэлтсээс бэлтгэсэн зохиомж

"Өв залгамжлалтай холбоотой маргаан" сэдвээр Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Золзаяагийн өгсөн ярилцлага, мөн сэдвээр хэвлэлийн хэлтсээс бэлтгэж өгсөн зохиомж, ярилцлагад зөвлөж ажилласан.



ТАМГЫН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

1. Шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах

Шүүхийн тамгын газар нь Шүүхийн тухай багц хууль, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль, тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохих ёсоор гүйцэтгэх, Шүүхийн захиргааны тухай хуулийн **6-12** дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх талаар анхааран ажиллалаа.

Захиргаа удирдлагын хэлтсээс Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2016 оны байдлаар шинэчлэгдсэн маягтыг дахин гаргуулан авч, **24** шүүгчийн материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Сахилгын хороонд, **1** хүний материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн ажлын албанд, **51** захиргааны албан хаагчийн материалыг Тамгын газарт зохих журмын дагуу хадгалж, цахим хэлбэрээр шинэчлэн гаргуулсан байна.

Мөн захиргааны албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн **8** хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг “**Авлигатай тэмцэх газар**”-т хянуулахаар хүргүүлэн холбогдох зөвшөөрлийг авч, шийдвэрлэжээ.

Түүнчлэн “**Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан**”-г шинэчилсэн програмын дагуу гаргаж, Төрийн албаны зөвлөл, Шүүхийн ерөнхий зөвлөлд тогтсон хугацаанд нь хүргүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж, шүүхийн байгууллагад олон жил, үр бүтээлтэй ажилласан Улсын Дээд шүүхийн шүүгч **Л.Атарцэцэгийг** Монгол Улсын “Гавъяат хуульч” цолоор, шүүгч **Ч.Хосбаярыг** “Хөдөлмөрийн гавъяаны Улаан туг”-ийн одонгоор, Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, шүүгч **Г.Алтанчимэг** нарыг “Алтангадас” одонгоор тус тус шагнажээ.

Мөн Улсын дээд шүүхийн Тамгын газрын Эрх зүйн онол, арга зүйн асуудал хариуцсан референт **Ш.Даваадулам** “Шүүхийн тэргүүний ажилтан” тэмдгээр шагнагдлаа.




Тайлангийн хугацаанд Тамгын газрын дарга хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **166** тушаал гаргасан байна.

“Билгийн тооллын хаврын тэргүүн сар-Цагаан сарын баяр”, “Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр”, “Хүүхдийн баяр”, “Үндэсний их баяр наадмын өдөр”, “Их Эзэн Чингис хааны өдөр”, “Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр”, “Шинэ жилийн баярын өдөр” болон бусад тэмдэглэлт баяр, бүх нийтийн амралтын өдрүүдэд тухай бүр арга хэмжээг зохион байгуулж, Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор Тамгын газрын даргын **7** удаагийн тушаалаар **14** ажилтныг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллуулжээ.

Мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Хуульч, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсны дараа шүүхэд төлөөлөх эрх нээлгэхээр Улсын Дээд шүүхэд бүртгүүлж ... өмгөөлөгчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдэнэ.” гэж заасны дагуу Тамгын газрын даргын тушаалаар 2013 оноос одоог хүртэл **2640**, энэ онд **227** хуульчдад өмгөөлөгчийн шүүхэд төлөөлөх эрхийг тус тус нээж, гэрчилгээ, үнэмлэх олгоод байна.

Тайлангийн хугацаанд **304** өргөдөл гомдол, **944** албан бичиг, **3361** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгч, Тамгын газрын даргад танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хувиарлан өгч шийдвэрлүүлснээс гадна **4003** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ.





Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зориг, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Т.Уранцэцэг, Иргэний хэргийн танхимын тэргүүн Х.Сонинбаяр, Захиргааны хэргийн танхимын тэргүүн М.Батсуурь нар тус шүүхэд ажиллаж байгаад гавъяаныхаа амралтад гарсан ахмадуудаа **“Цагаан сар”**, **“Ахмадын өдөр”**-ийг тохиолдуулан 2017 оны 2 дугаар сарын 17-ны өдөр болон 9 дүгээр сарын 23-ны өдрүүдэд хүлээн авч уулзан, хүндэтгэл үзүүллээ.

Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2017 оны 5 дугаар сарын 29-ний 1/4552 дугаартай хамтран ажиллах тухай албан бичгийг ирүүлсний дагуу Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Засгийн газрын 2013 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам”-ыг тус тус үндэслэн төрийн байгууллага хоорондын ажлын уялдааг хангаж, хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээллийг цахим хэлбэрээр солилцож үйл ажиллагаандаа ашиглах, төрийн үйлчилгээг хялбаршуулах зорилгоор Улсын Дээд шүүх болон Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар хооронд 2017 оны 6 дугаар сарын 05-ны өдөр **“Мэдээлэл солилцох гэрээ”** байгуулан хамтран ажиллахад бэлэн болоод байна.

Улсын Дээд шүүхийн баг, тамирчид Нийслэлийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс 2017 оны 5 дугаар сарын 5-14-ний өдрүүдэд зохион байгуулсан **“Нийслэлийн шүүх байгуулагдсаны 90 жил”**-ийн спортын 6 төрөлт тэмцээнд;

Мөн Багануур дүүргийн эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2017 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан **“Нийслэлийн шүүхүүдийн дунд зохион байгуулсан хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн”**-д тус тус амжилттай оролцож, багийн нийлбэр дүнгээр тэргүүлж, цомын эзэд боллоо.

Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2017 оны 11 дүгээр сарын 22-25-ны өдрүүдэд зохион байгуулсан **“Хуулийн төв байгууллагуудын спортын их наадам”**-д баг, тамирчид амжилттай оролцлоо.

Шүүхийн хүний нөөцийн чиглэлээр:

Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн шүүгч **Т.Уранцэцэгийг** Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 73 дугаар зарлигаар Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний албан тушаалаас;

Тамгын газрын даргын тушаалаар **Ч.Нямсүрэнг** Шүүхийн практик судлалын хэлтсийн даргын албан тушаалаас;

А.Пүрэвдуламыг Бичиг хүргэгчийн ажлаас тус тус чөлөөлжээ.



Тайлангийн хугацаанд **М.Солонгоо, А.Энхжаргал, Ц.Энхтүвшин** нарыг шүүгчийн туслах-шинжээчийн, **С.Одмааг** бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээчийн, **Г.Хэрлэнчимэгийг** шүүх таслах ажиллагааны аюулгүй байдал хариуцсан шинжээчийн, **Г.Цэрэнжамцыг** захиргааны хэргийн хууль тогтоомж, практик ажил хариуцсан шинжээчийн, **Б.Бадмарага, А.Батдэлгэр, Э.Боролдой** нарыг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтний, хүүхэд асрах чөлөө дуусахаас өмнө ажилдаа орох хүсэлт гаргасан **Б.Дүүрэнжаргалыг** архивын ажил хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн тус тус томилж, өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан захиргааны хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **Г.Мөнхсайхан, Т.Жавхлантөгс**, иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **И.Бямбасүрэн, С.Цэрэндулам**, жолооч **Ч.Одгэрэл** нарыг чөлөөлсөн байна.

Түүнчлэн Тамгын газрын даргын тушаалаар шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтэн **С.Баяртуяа, З.Оюунгэрэл, И.Хажидмаа** нарыг шүүгчийн туслах-шинжээчийн, бичиг хүргэгч **Г.Гантогтохыг** шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтний, үйлчлэгч **Б.Уртнасанг** бичиг хүргэгчийн ажилд тус тус дэвшүүлэн ажиллуулжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Улсын Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсон **Г.Банзрагчийн** шүүгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа Улсын Дээд шүүхэд 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр боллоо.

Тайлангийн хугацаанд:

Захиргаа удирдлагын хэлтсийн дарга **Д.Отгонбаатар**, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга **Н.Булгамаа**, Шүүхийн зохион байгуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Алтанцэцэг**, Хүний нөөц, сургалт хариуцсан ахлах референт **С.Бурмаа**, Мэдээллийн технологи хариуцсан референт **Э.Баярбаатар**, Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч **О.Батсүх**, Мэдээлэл лавлагааны ажил хариуцсан ахлах шинжээч **Б.Чимгээ**, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээч **М.Солонгоо**, Шүүгчийн туслах-шинжээч **Д.Даваадорж, М.Далайхүү, Т.Майцэцэг, С.Цэрэндулам**, Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтэн **Ш.Мөнхжаргал** нарын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг;

Улсын Дээд шүүхийн Захиргаа удирдлагын хэлтсийн дарга **Д.Отгонбаатар**, Иргэний хэргийн танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч **Н.Мөнхтулга**, шүүгчийн туслах-шинжээч **Г.Мөнхсайхан** нарт төрийн



захиргааны албан тушаалын зэрэг дэвийг шинээр олгож, нярав **А.Ичинхорлоо**, жолооч **Д.Лхагвасүрэн**, цахилгаанчин **Э.Өлзийбаяр** нарын ур чадварын нэмэгдлийг шинээр буюу нэмэгдүүлэн олгосон байна.

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу давхардсан тоогоор **63** хүний үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх, **21** хүний хөдөлмөрийн гэрээг байгуулах ажлыг хагас, бүтэн жилээр зохион байгууллаа.

Мөн Тамгын газрын даргын туслах-шинжээч **А.Эрдэнэт**, иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч **И.Хажидмаа**, шүүн таслах ажиллагааны аюулгүй байдал хариуцсан шинжээч **Г.Хэрлэнчимэг** нарын Төрийн албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан байна.

2. Шүүхийн практик судлах чиглэлээр:

Шүүхийн практик судлалын хэлтэс нь 2017 онд шүүхийн практикийг судлах, хууль тогтоомжид санал өгөх, хууль тогтоомжийн системчлэлийн ажлыг хийж гүйцэтгэх, ном тохимол, сэтгүүл гаргах чиглэлээр төлөвлөсөн цаг хугацаанд нь бүрэн хийж гүйцэтгэлээ.

Нэг. Шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд:

Тус хэлтэс нь 2017 онд эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн практикийг судалж, дараах чиглэлээр судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1.1. Эрүүгийн хэргийн талаарх шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд:

1. Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн байдлын талаарх танилцуулга /2014-2016 он/;
2. Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлээр /Хүнийг санаатай алах/ шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн талаарх танилцуулга;
3. Хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн гадаадын хөрөнгө оруулагчтай холбоотой хэргийн танилцуулга /2014-2016 оны байдлаар/;
4. Хяналтын шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн судалгаа /2012-2016 он/-г хийж танилцуулга;
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн эрх, хэмжээний талаарх танилцуулга;
6. Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргийн танилцуулга /2014-2016 он/;



7. Эрүүгийн хуулийн 140, 141, 168 дугаар зүйлүүдээр шийдвэрлэсэн хэргийн танилцуулга /2012-2016 он/;
8. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар 2016 оны бүтэн жилд хянагдсан эрүүгийн хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон тогтоол, магадлалыг судалж, уг судалгаанд үндэслэн тойм;
9. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар 2016 оны эхний хагас жилд хянагдсан эрүүгийн хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон тогтоол, магадлалыг судалсан тухай (тойм);
10. Эрүүгийн хуулийн 40 дүгээр зүйл /Аргагүй хамгаалалт/-ийг журамлан шийдвэрлэсэн хэргийн судалгаа /2013-2016 он/;
11. Хяналтын шатны шүүхээр мөрдөн байцаалтад буцааж шийдвэрлэсэн хэргийн судалгаа /2014-2016 оны байдлаар/;
12. Эрүүгийн хуулийн харьцуулсан багц судалгаа;
13. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль дахь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны харьцуулсан судалгаа;
14. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол болон хохирогчдын төлөв байдлын судалгаа /ЦЕГ-ын тайлан мэдээнд үндэслэн 2007-2016 оны байдлаар/;
15. Авилга, албан тушаалын гэмт хэргийг шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн судалгаа /2010-2013 он/;
16. Мансуурах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийг шүүхэд шийдвэрлэсэн практикийн талаарх судалгаа /2014- 2017 оны эхний хагас жил/;
17. Хүн худалдаалах гэмт хэргийг шүүхэд шийдвэрлэсэн практикийн талаарх судалгаа /2012- 2017 оны эхний хагас жил/;
18. Эрүүгийн хуулийн 113, 124 дүгээр зүйлүүдээр шийдвэрлэгдсэн хэргийн судалгаа /2012-2016 он/;
19. Төв аймгийн гэмт хэргийн нөхцөл байдал /2007-2016/ судалгаа;
20. “Төв аймгийн эрүүгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ” гэмт хэргийн цагаан номд орох материал /2007-2016/ судалгаа зэрэг болно.

1.2. Иргэний хэргийн талаарх шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд:

1. Гадаадын хөрөнгө оруулалттай компанитай холбоотой иргэний хэрэг, маргааны талаар танилцуулга;



2. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанаар 2017 оны 1 дүгээр улиралд хянагдсан хэргийн тойм;
3. Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр 2016 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн тойм;
4. Ерөнхий шүүгч нарын уулзалтад хяналтын шатны шүүхээр 2016 онд хяналтын шатны шүүх хуралдаанаас шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон иргэний хэргийн талаар шүүх тус бүрээр гаргасан тойм;
5. ИХШХШТХ-ийн 176 дугаар зүйлийн 176.2.3 дахь заалтын дагуу шийдвэрлэсэн хэргүүдээс жишиг болох хэргүүдийн судалгаа;
6. 2013-2016 онд Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай, Патентийн тухай хуулиар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн судалгаа;
7. 2016-2017 оны 1 дүгээр улирлын байдлаар Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн шүүхийн шийдвэрлэгдсэн хэргийн талаар тойм, судалгаа;
8. 2012-2017 онд Дампуурлын тухай хуулиар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийн судалгаа;
9. Гэр бүлийн маргаантай хэргийг сүүлийн 10 жилд шүүхээр хянан шийдвэрлэсэн хэргийн судалгаа;
10. Сүүлийн 2 жилийн хугацаанд хэргийг хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэхдээ Иргэний эрх зүйн зарчмыг дурьдаж, хэрэглэсэн хэрэг маргааны судалгаа;
11. Хяналтын шатны шүүхээр 2016 онд худалдах худалдан авах гэрээнээс үүссэн маргааныг хянан шийдвэрлэсэн хэрэг маргааны шийдвэрлэлтийн судалгаа;
12. Гэрээний бус маргаан буюу нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан хэргийн сүүлийн 5 жилийн судалгаа зэрэг болно.

1.3. Захиргааны хэргийн талаарх шүүхийн практикийг судлах ажлын хүрээнд:

1. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2016 онд хянан шийдвэрлэсэн Нийгмийн даатгал болон төрийн албаны маргаанууд лавлагаа, танилцуулга;
2. Захиргааны хэргийн судалгааны тойм танилцуулга. /Багц судалгаа/
3. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2016 онд хянагдсан захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон шийдвэр, магадлалыг судалсан тухай тойм;



4. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2017 оны эхний хагас жилд хянагдсан захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон шийдвэр, магадлалыг судалсан тухай тойм;
5. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2016 онд хянагдсан захиргааны хэргийн өөрчлөгдсөн, хүчингүй болсон шийдвэр, магадлалын алдаа, зөрчлийн тойм;
6. 2016 онд Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэгдсэн хэргүүдэд шинжээч томилогдсон эсэх тухай судалгаа;
7. 2016 онд Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхимын хянан тогтоосон хэргийн шийдвэр, маргааны судалгаа;
8. 2016 онд Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн төрийн албан хаагчийн хөдөлмөрийн маргааны судалгаа;
9. Хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн гадаадын хөрөнгө оруулагчтай холбоотой хэргийн танилцуулга судалгаа /2014-2016 он/;
10. Үндсэн хуулийн шинэчилсэн өөрчлөлтийн төсөлд зориулсан Дэлхийн улс орнуудын шүүх эрх мэдлийн Үндсэн хуулийн эрх зүйн харьцуулсан судалгаа;
11. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хянан хэлэлцээд тогтоосон шийдвэр /газрын маргаанаар 2016 он бүтэн жил, 2017 он хагас жил/ лавлагаа статистик судалгаа;
12. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар хэрэг хянан хэлэлцэж шийдвэр гаргахдаа хэрэглэсэн хууль, эрх зүйн актууд, Захиргааны ерөнхий хуулийн шүүхийн практик хэрэглээний судалгаа;
13. Байгал орчны чиг үүргийн яамны сайд хариуцагчаар оролцож, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар шийдэгдсэн маргаан /2016 он бүтнээр, 2017 оны эхний хагас жилд/ статистик судалгаа;
14. Ашигт малтмалын тухай хуулиар шийдэгдсэн Ашигт малтмалын газар хариуцагчаар оролцсон маргааны /2016 он бүтнээр 2017 оны эхний хагас жил/ судалгаа;
15. Хөрш улс орнуудтай байгуулсан хамтын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хамтын ажиллагааны талаарх судалгаа;
19. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг бусад 5 улсын хуультай харьцуулан хийсэн судалгаа;



20. Монгол Улс дахь хүний эрхийг хамгаалах тогтолцоо: эгзэгтэй үе дэх шүүх эрх мэдэл. Эрх зүйн баримт бичгийн мэдээллийн судалгаа;

21. 2017 оны 11 дүгээр сарын 27-ны байдлаар/ Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн маргааны судалгаа;

22. Шүүхийн хараат бус байдал. Эрх зүйн актуудын /Шүүхийн тухай хууль. 1993, 2002, 2012/ түүхчилсэн харьцуулалт болон баримт мэдээллийн судалгаа;

23. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хянан хэлэлцээд тогтоосон шийдвэр /оюуны өмчийн маргаан 2016 он бүтэн жил, 2017 он хагас жил/ лавлагаа статистик судалгаа;

24. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хянан хэлэлцээд тогтоосон шийдвэр /хуулийн этгээдийн улсын бүртгэл 2016 он бүтэн жил, 2017 он хагас жил/ лавлагаа статистик судалгаа зэрэг болно.

Хоёр. Хууль тогтоомжийн системчлэлийн ажлын талаар

2017 онд Ерөнхийлөгчийн тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газраас манайд ирүүлж байгаа Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их хурлын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн тогтоол, дүгнэлт, Төрийн мэдээлэл сэтгүүлүүдийг дугаар бүрээр нь хүлээн авч шүүгч, ажилтнуудад эх хувиар болон дотоод сүлжээгээр дамжуулан ашиглуулж лавлагаа өгч, шүүхийн мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд Монгол Улсын хууль **270** хүлээн авч, **221** хуульд нэмэлт, өөрчлөлт орж, **16** хууль хүчингүй болсныг эх хуульд тухай бүрт нь хийхийн зэрэгцээ нэгдсэн сан дахь хуулиудад өөрчлөлтийг давхар оруулсан байна.

Тухайлбал:

- Монгол Улсын хууль-**270**;
- Улсын Их Хурлын тогтоол-**61**;
- Ерөнхийлөгчийн зарлиг- **27**;
- Төрийн мэдээлэл сэтгүүлийн **41** дугаар;
- Үндсэн хуулийн цэцийн тогтоол, дүгнэлт-**7** тус бүр хүлээн авч эх хувь болон нэгдсэн санд оруулсан ба хууль тогтоомжийг шүүгч, ажилтнуудын шүүн таслах болон албан ажлын хэрэгцээнд гарын авлага болгон ашиглуулж байна.



Гурав. Ном тохимол, сэтгүүл, эрдэм шинжилгээний хурлын талаар

“Монголын төр эрх зүй” сэтгүүлийн 2016 оны 4, 2017 оны 1, 2, 3 дугаар дугаарыг;

“Монголын шүүх” 1 дүгээр ботийн 2 дахь хэсгийг;

Хэлтсийн дарга Ч.Нямсүрэн нь Гэмт хэргийн цагаан номонд “Гэмт хэргийн хохирогч судлалын төлөв байдал” дэд тайлан тус тус хэвлэн нийтлүүлжээ.

Мөн шинжээч А.Баярцэцэг нь Хууль сахиулахын их сургуулиас зохион байгуулсан “Монгол Улс дахь гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал” эрдэм шинжилгээний хуралд “Шүүхийн статистик программын хэрэглээ, хяналтын шатны шүүх хуралдааны шийдвэрийн өгөгдлийн сан” сэдвээр;

Хэлтсийн дарга Ч.Нямсүрэн нь ОӨУБЕГ, Хууль сахиулах их сургууль хамтран зохион байгуулсан “Гэр бүлийн хэрэг маргааныг шүүхийн журмаар шийдвэрлэж буй өнөөгийн байдал, тулгамдаж буй зарим асуудал” сэдвээр;

Гэмт хэргийн хохирлын үнэлгээ, түүнийг тооцож буй практик сэдвээр;

Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөний үер зохион байгуулсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн нөхцөл байдал цаашид анхаарах асуудал” сэдэвт онол практикийн бага хуралд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онолын зарим асуудал, гадаад орнуудын туршлага” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлжээ.

Мөн Шүүхийн шинжилгээний байгууллагын төв орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөнд Ч.Нямсүрэн “Шүүх, шүүхийн шинжилгээний хамтын ажиллагаа, тулгамдаж буй асуудал цаашдын зорилт” сэдвээр хичээл заажээ.

3. Шүүхийн санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр:

Улсын Дээд шүүхийн 2017 оны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу тус хэлтэс нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлэх, санал дүгнэлт гаргуулах, төсвийн төлөвлөлтийг оновчтой зөв тооцон боловсруулах, батлуулах, хуваарилах, батлагдсан төсвийг хууль, тогтоомжийн дагуу зөв зохистой зарцуулах, төсөв санхүү болон бусад холбогдох хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг хангах, шүүхийн санхүүгийн үйл ажиллагааг хөтлөх зэрэг үндсэн чиг үүргийн ажлуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийн тухай хуулиар Улсын Дээд шүүхийн төсвийн багц **4.0** тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд 2017 онд нийтдээ улсын төвлөрсөн төсвөөс урсгал



үйл ажиллагааны санхүүжилтээр **4.0** тэрбум төгрөг авахаас **4.0** тэрбум төгрөгийн санхүүжилт авч **3.6** тэрбум төгрөгийг зарлага гаргаж, 88%-ийн төсвийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Улсын Дээд шүүхийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гарган тайлагнаж, аудит хийлгэх, нэгтгүүлэхээр Үндэсний Аудитын газар, Сангийн яамны Төрийн сангийн газруудад хүргүүлсэн.

Үндэсний Аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, МУ-ын Ерөнхий аудиторын 2015 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын шаардлагыг Улсын Дээд шүүхийн санхүүгийн байдал нь бүрэн хангаж байна гэж дүгнэн, “**Зөрчилгүй**” санал дүгнэлт гаргаж, “**Итгэл**” үзүүлэн итгэмжлэл олгож тус хэлтсийн ажлыг дүгнэлээ.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх хэсэгт заасны дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан Улсын Дээд шүүхийн 2018 оны урсгал төсвийг **7.9** тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын төсвийг **20.7** тэрбум төгрөг буюу нийт **28.6** тэрбум төгрөгөөр төлөвлөж, хязгаарын саналыг боловсруулж холбогдох газарт хүргүүллээ.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналтын шатны шүүхийн хэвийн ажиллагааг хангахад зарцуулсан бөгөөд сургалт семинар зохион байгуулах, зочин төлөөлөгч хүлээн авах, томилолтоор ажиллах зэрэг үйл ажиллагааны зардалд **225.9** сая төгрөг, шүүхийн ахмад ажилчдыг хүлээн авах, шагнал, мөнгөн урамшуулал, тэтгэмжийн зардалд **32.9** сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд **118.1** сая төгрөгийг тус тус гаргасан байна.

Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмын 7.1.3-т “**шүүгч, ажилтныг шаардлагатай тавилга, тоног төхөөрмж, техник хэрэгслээр хангах**” гэж заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохих зөвшөөрөл авснаар **50.9** сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж авч үндсэн болон эргэлтийн хөрөнгөнд бүртгэж, ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.

Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах, хяналтын шатны шүүн таслах ажлыг таниулах, сурталчлах, хэргийн оролцогч, иргэд, хуулийн этгээдэд түргэн шуурхай мэдээлэл хүргэх мэдээлэл сурталчилгааны ажил, вирусны програм суулгах зэрэг ажлуудыг **14.0** сая төгрөгөөр, хяналтын шатны шүүхийн 2016, 2017 онуудын тайлан, Захиргааны хэргийн хуулийн тайлбар болон “Монголын шүүх”



боть номны үргэлжлэлийг хэвлүүлэх зэрэг ажлуудыг **14.0** сая төгрөгөөр тус тус санхүүжүүлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйлд заасны дагуу “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллого” болохтой холбогдуулан Тамгын газрын даргын 2017 оны 6 дугаар сарын 09-ны өдрийн А/42, 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/64 дугаар тус тус тушаалаар хөрөнгийн тооллого зохион байгуулах, хэрэгжүүлэх комисс байгуулагдан хагас, бүтэн жилийн хөрөнгийн тооллогыг хийж, нэгдсэн дүнг тайлагнаж, Төрийн өмчийн тооллогын бэлтгэл ажлыг бүрэн хангасан болно. Хагас жилийн тооллогын үр дүнд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын дагуу тус газартай гэрээ байгуулж, өмнөх жилийн ажлыг 98%-ийн үнэлгээтэй дүгнүүлж, Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх, Давж заалдах шатны шүүхүүдийн байрыг шилжүүлэн авах ажлыг хуралдаанаар оруулж, Засгийн газарт шилжүүлэх саналыг хүргүүлээд байна.

Мөн “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-ийн програм хангамжинд Улсын Дээд шүүхийн 2016 оны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдэл, холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь багтаан орууллаа.

Улсын Дээд шүүхийн санхүүгийн үйл ажиллагааг хөтлөн явуулах, тайлан бэлтгэх, гаргахад шаардагдах нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг УСНББОУС-ийн агууллагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, Төсвийн Ерөнхийлөн захирагчаар батлуулан гаргалаа.

Дээрх өмч хөрөнгийн тооллого болон урсгал засварын ажлыг эхлэхтэй холбогдуулж, 2017 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Улсын Дээд шүүхийн байрны халаалтын автомат тохируулагч, бохирын худаг, агуулахын ерөөний дотоод засвар, өрөөнүүдийн хаалга солих, Ар гүнтийн аманд хашаа шинээр хийх, хяналтын камер нэмэх, хурлын залны микрофон солих, ширээний компьютер авах, серверийг бүрэн шинэчлэх, бичлэг хадгалах хард, тог баригч шинэчлэх, 1-р байрны нийтлэг үйлчилгээний хэсгийг шинэчлэн засварлах, цонхны резин солих, дээврийн битүүмжлэл зэрэг засвар, худалдан авалтын ажлуудыг зохион байгуулан хийж гүйцэтгэж, мөн сонгон шалгаруулалтыг хэрэгжүүлэх болон өөрсдийн дотоод нөөцөд тулгуурлаж **142.5** сая төгрөгийн засварын ажлуудыг хийж гүйцэтгэтгэсэн байна.

Түүнчлэн авто тээврийн хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг хангах, даатгал, оношлогоо, газрын хураамж болон шүүгч нарын эрүүл мэндийн даатгал, мэдээллийн технологийн зардалд **69.6** сая төгрөгийг зарцуулсан байна.



Мөн шүүгч ажилтнуудыг шаардлагатай бичиг хэрэг, хангамжийн материалаар хангах болон бараа материал, нормын хувцас, шатахууны зардалд **133.6** сая төгрөг, байр ашиглалтын зардалд **76.1** сая төгрөг, цалин, НДШ-д **2698.3** сая төгрөгийн зарлага гаргаснаар 2017 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг батлагдсан төсвийн хэмжээнд бүрэн санхүүжүүлж, дэмжин ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд www.shilendans.gov.mn болон Улсын Дээд шүүхийн сайт дахь Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бүтэн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш хэмжээтэй зардал зэрэг холбогдох шаардлагатай мэдээ, мэдээллүүдийг цаг тухай бүрт нь хуулийн хугацаанд оруулах, шүүхийн 2017 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг e-procurement.mn сайт дээр байршуулах зэргээс гадна холбогдох тайлан, мэдээг гаргаж Сангийн яам болон бусад газруудад хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж байна.

4. Шүүхийн зохион байгуулалтын чиглэлээр:

Тус хэлтэс нь шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах нөхцлийг хангах ажлыг зохион байгуулан, шүүх хуралдааны танхим, техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангах, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийн төсөл боловсруулах, ёсчлуулах, тэдгээрийг www.shuukh.mn болон www.supremecourt.mn цахим хуудсанд байршуулах, шүүх хуралдааны тэмдэглэл хөтөлж, шүүх хуралдааныг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулах, шүүн таслах ажиллагааны хагас, бүтэн жилийн мэдээ тайлан гаргах ажлыг зохион байгуулах зэрэг хуульд заасан бусад чиг үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.

Танхимын тэргүүний туслах, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын ажлын зохион байгуулалт, хэргийн хөдөлгөөний аргачлал, албан хэрэг хөтлөлт, цахим санд шүүхийн шийдвэр нийтлэх журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2016 онд Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн тогтоолыг Shuukh.mn сайтад бүрэн байршуулсан.

Мөн 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авсан Улсын Дээд шүүхийн шинэ вэб сайтад “хяналтын шатны шүүх хуралдааны зар, тойм, статистик мэдээ”-г тус тус тогтмол байршуулж байна.



Тайлангийн хугацаанд Цагдаагийн байгууллагаас шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангаж шүүх хуралдааны журам сахиулан ажиллах хугацаанд Б.Содномдаржаа, Ц.Амгаланбаатар, Т.Чимгээ, Г.Дэнзэн, Г.Батжаргал нарт холбогдох эрүүгийн хэрэг, намуудын бүртгэл, хүсэлт зэргийг шийдвэрлэсэн онцлох шүүх хуралдаанууд болж өнгөрлөө.

Мөн хугацаанд тус хэлтэс нь байгууллага, албан тушаалтан, иргэнээс ирсэн нийт 133 өргөдөл, гомдол, хүсэлтийг зохих журмын дагуу хүлээн авч, судлан холбогдох албан тушаалтанд танилцуулан, хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хариуг уламжилсан байна.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасан чиг үүргийн дагуу /шүүгчийн туслахууд/ шүүгчид хуваарилагдсан хэрэг, маргааны талаарх бичиг баримтын бүрдлийг судалж, хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүгчээс даалгасан ажиллагааг гүйцэтгэх, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, шаардлагатай хууль тогтоомжийн талаар мэдээлэл бэлтгэх, хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах зэрэг ажлуудыг гүйцэтгэжээ.

Шүүхийн захиргааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасан чиг үүргийн дагуу /шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар/ шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангаж эрүүгийн шүүх хуралдааны **395**, иргэний **1468**, захиргааны **651** нийт **2514** шүүх хуралдааны тэмдэглэл тус тус хөтлөж, шүүх хуралдааны дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулж, шүүх хуралдааны тэмдэглэлийг хэргийн оролцогчдод хуульд заасан хугацаанд танилцуулан, шүүгчээр баталгаажуулж, хэргийн материалд хавсаргажээ.

Улсын Дээд шүүхийн шүүн таслах, шүүхийн нийтлэг үйлчилгээний ажлыг хэвийн, тасралтгүй явуулах нөхцлийг ханган, цахим санд хяналтын шатны шүүх хуралдааны зар, тойм **2700**-г байршуулж, хяналтын шатны шүүх хуралдааны эрүүгийн **342**, иргэний **1704**, захиргааны **543** тогтоолыг тус тус байршуулан ажилласан байна.

5. Шүүхийн хэвлэл мэдээллийн чиглэлээр:

Улсын Дээд шүүхийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс 2017 оны 01 дүгээр сараас 12 дугаар сарын 22-ныг дуусталх хугацаанд Улсын Дээд шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагааны талаар өдөр тутмын сонинд



114, телевизэд 217, радиод 58, вэб сайтуудад 536 мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлж нэвтрүүлжээ.

Телевизийн нэвтрүүлгийн хувьд:

Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч **Б.Цолмонбаатар** 2017 оны 5 дугаар сарын 22-ны өдөр **МҮОНТ**-ийн “**Эрх зүйн хөтөч**” нэвтрүүлэгт оролцож, “**Гэр бүл, хүүхдийн тэтгэлэг**” сэдвээр;

Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч **С.Буд** 2017 оны 5 дугаар сарын 29-ний өдөр **МҮОНТ**-ийн “**Эрх зүйн хөтөч**” нэвтрүүлэгт оролцож, “**Худалдах худалдан авах гэрээ, орон сууцны зөрүүтэй холбоотой маргааныг шийдвэрлэж буй шүүхийн практик**” сэдвээр;

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр “**Эрх зүйн хөтөч**” нэвтрүүлэгт оролцож, “**Төрийн албаны маргаан**” сэдвээр;

Улсын Дээд шүүхийн шүүгч **Г.Банзрагч** 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр **МҮОНТ**-ийн “**Эрх зүйн хөтөч**” нэвтрүүлэгт оролцож, “**Нийгмийн даатгалтай холбоотой маргаан**” сэдвээр;

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч **Б.Нармандах** 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр **МҮОНТ**-ийн “**Эрх зүйн хөтөч**” нэвтрүүлэгт оролцож, “**Онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа**” сэдвээр тус тус ярилцлага өгчээ.

Мөн 2017 оны 5 дугаар сарын 22-ны өдөр “**Хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой маргаан**” сэдвээр, 2017 оны 5 дугаар сарын 29-ний өдөр “**Худалдах худалдан авах гэрээ, орон сууцны зөрүүтэй холбоотой маргаан**” сэдвээр, 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр “**Төрийн албаны маргаан**” сэдвээр, 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр “**Нийгмийн даатгалын маргаан**” сэдвээр, 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр “**Онцгой ажиллагааны журмаар ажилласан жил тогтоолгох нь**” сэдвээр тус тус зохиомжит нэвтрүүлэг хийсэн байна.

Сонин, сайтын нийтлэлийн хувьд:

Шүүхийн талаар бодит ойлголт олон нийтэд хүргэх үүднээс шүүхийн шинэчлэл болон шүүх, шүүгчийн үйл ажиллагаа, шүүхийн шийдвэртэй холбоотой давхардсан тоогоор нийт **56** нийтлэл, ярилцлага, сурвалжлага, мэндчилгээ, хагас, бүтэн жилийн ажлын дэлгэрэнгүй мэдээллийг өөрсдөө бэлтгэх буюу сэтгүүлчдээр бэлдүүлэн сонин, сайтад нийтлүүлжээ.




6. Ерөнхий шүүгчийн ажлын алба:

Тус алба нь тайлангийн хугацаанд нийт **42** албан бичиг, **121** өргөдөл, гомдол хүлээн авч, хуулийн хугацаанд нь хариу өгчээ.

Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг үндэслэн Ерөнхий шүүгчийн ажлын алба эрүүгийн **12**, иргэний **2**, захиргааны **80**, нийт **94** хэрэг хүлээн авч, Ерөнхий шүүгчид танилцуулж, хариу өгсөн байна.

Өмнөх онтой харьцуулбал:



Ажлын албаны дарга, бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээчийг байлцуулан хэргийн оролцогчид болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгч **142** иргэнийг сар бүрийн **4** дүгээр **7** хоногийн **пүрэв** гарагт болон хөдөө орон нутгаас ирсэн иргэдийг тухайн өдөрт нь хүлээн авч уулзан санал хүсэлтийг нь сонсож, тэдний санал, хүсэлтийг Ерөнхий шүүгчид тухай бүрт нь танилцуулж, зохих хариуг өгчээ.

Ерөнхий шүүгчид хандаж гаргасан гомдлын дагуу эрүү, иргэний болон захиргааны хэргийг хянах явцад шүүх, шүүгчдийн болон захиргааны ажилтнуудын гаргасан алдаа, зөрчилд анхаарах асуудлаар тусгайлан бүртгэл хөтөлж, шүүгч, ажилтанд энэ талаар мэдэгдэж, зөвлөмж өгч ажиллажээ.



7. Шүүхийн гадаад арга хэмжээний чиглэлээр:

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжин тэлж шүүгч, ажилтнууд тив дэлхийн болон олон улсын бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцож шүүн таслах ажиллагааны талаарх туршлага судлах ажил өргөжсөөр байна. Тухайлбал:

Ерөнхий шүүгч **Ц.Зориг**, Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв**, Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** нар 2017 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 02 дугаар сарын 03-ны өдрүүдэд Тайландын Вант Улсын Бангкок хотноо зохион байгуулагдсан “**Шүүн таслах ажиллагаа**” сэдэвт олон улсын бага хурал, семинарт;

Ерөнхий шүүгч **Ц.Зориг**, Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв**, Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** БНСУ-ын Сөүл хотноо 2017 оны 01 сарын 25-27 өдрүүдэд Монгол Улсын Дээд шүүх болон “**БНСУ-ын Дээд Шүүхийн хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийн талаар**” албан уулзалтад;

Иргэний хэргийн танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, шүүгч **Ц.Амарсайхан**, **Л.Атарцэцэг**, **Ч.Тунгалаг**, **Д.Эрдэнэбалсүрэн**, Захиргаа удирдлагын хэлтсийн дарга **Д.Отгонбаатар** нар Испанийн Вант Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч ноён Карлос Д.Серраногийн урилгаар тус улсын Мадрид, Барселон хотуудад 2017 оны 04 дүгээр сарын 04-09-ний өдрүүдэд “**Монгол Шүүхийн шүүгч, ажилтан нарт зориулсан сургалт**” сэдэвт сургалтад;

шүүгч **Г.Банзрагч**, **П.Соёл-Эрдэнэ** нар Олон Улсын Худалдааны Арбитрын зөвлөл болон Азийн Олон Улсын Эрх зүйн академиас 2017 оны 5 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд БНХАУ-ын Онцгой захиргаат Хонконг хотноо зохион байгуулагдах “**Нью Йоркийн конвенцын талаарх сургалт**” сэдэвт сургалтад;

шүүгч **Т.Цогт** 2017 оны 5 дугаар сарын 16-20 өдрүүдэд ОХУ-ын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагддаг Санкт Петербургийн олон улсын хуулийн форум” сэдэвт олон улсын хурал, семинарт;

Эрүүгийн хэргийн Танхимын тэргүүн **Т.Уранцэцэг**, шүүгч **Ч.Хосбаяр**, **Х.Эрдэнэсүвд** нар Бүгд Найрамдах Франц улсын Парис хотноо 2017 оны 05 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “**Олон Улсын шүүхийн чуулган**” сэдэвт олон улсын хурал, сургалтад;

шүүгч **Ч.Хосбаяр** Нидерландын Вант Улсын Гаага хотноо Олон Улсын Эрүүгийн шүүхийн Нарийн бичгийн дарга нарын газрын Шүүгчийг Сонгон



шалгаруулах зөвлөх хорооноос **Монгол Улсаас ОУЭШ-д нэр дэвшигчтэй 2017 оны 9 дүгээр сарын 18-наас 20 өдрүүдэд хийсэн уулзалтад;**

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Д.Тулга** нар БНХАУ-ын Ардын Дээд шүүхээс тус улсын Гансу мужын Дунханг хотноо 2017 оны 9 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд зохион байгуулагдах **“Торгоны замын бүс нутгийн шүүхийн хамтын ажиллагаа”** сэдэвт сургалт, форумд

Монгол Улсаас Олон Улсын Эрүүгийн шүүхийн шүүгчид нэр дэвшигч Улсын Дээд шүүхийн шүүгч **Ч.Хосбаяр** АНУ-ын Нью Йорк хотноо 2017 оны 11 дүгээр сарын 04-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан **Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн Оролцогч улсуудын төлөөлөгч нартай хийх уулзалтад;**

шүүгч **П.Золзаяа**, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч **С.Энхтөр**, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн шүүгч **Г.Билгүүн** Санхүү хангамж, үйлчилгээний хэлтсийн дарга **Н.Булгамаа**, Шүүхийн практик судлалын хэлтсийн дарга **Ч.Нямсүрэн**, Албаны даргын албан үүргийг орлон гүйцэтгэгч **Д.Тулга**, Төсвийн асуудал хариуцсан референт- Ахлах нягтлан бодогч **А.Эрдэнэцэцэг**, Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах ахлах шинжээч **О.Батсүх** нар БНЭУ-ын Дели болон Лакноу хотноо 2017 оны 11 дүгээр сарын 6-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан **Дэлхийн Ерөнхий шүүгч нарын чуулга уулзалтанд** тус тус оролцжээ.

Гадаад айлчлалын хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн **Бүгд Найрамдах Казахстан Улсад** 2017 оны 06 дугаар сарын 07-11-ний өдрүүдэд хийсэн албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** багтсан бөгөөд айлчлалын хүрээнд бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулжээ.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд:

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь**, Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв** нар Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, Хүний эрхийн газрын Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийг ажиглах түр хорооны тэргүүн, Элчин сайд, ноён **Гээрт-Хинрич Арэнс**, хуулийн шинжээч **Марианна Скопа** нарыг 2017 оны 6 сарын 13-ны өдөр;

шүүгч **Х.Батсүрэн** НҮБ-ын Эрүүл, аюулгүй, цэвэр, тогтвортой орчинд амьдрах эрхийн асуудал хариуцсан тусгай илтгэгч ноён **Жонн Кнокс** тэргүүтэй төлөөлөгчдийг 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр;



Ерөнхий шүүгч **Ц.Зориг** Монгол Улсад албан ёсны ажлын айлчлал хийж буй БНХАУ-ын Хууль зүйн сайд **Жан Жюнь** тэргүүтэй төлөөлөгчдийг 2017 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр тус тус хүлээн авч уулзлаа

Шүүхийн даалгаврын хүрээнд:

Шүүхийн даалгвар буюу эрх зүйн туслалцааг хилийн чандад илгээх болон хилийн чандаас ирсэн хүссэлтийг Иргэний хэргийн хувьд хариуцах Дээд шатны байгууллага нь Улсын Дээд шүүх бөгөөд гадаад улсад нийт 18 шүүхийн даалгвар илгээсэнээс БНСУ-д 8, БНХАУ-д 3, Болгор улсад 2, Беларусь, Украин, Чех, Польш, Казакстан улсуудад тус тус 1 шүүхийн даалгавр илгээгээд байгаагаас өмнөх онд буцаан ирүүлээгүй 4 шүүхийг даалгварын хамт нийт 14 шүүхийн даалгварын хариу хүлээлттэй байна.

Харин гадаад улсаас Австрали, БНСУ, Япон улсуудаас тус тус 1 шүүхийн даалгвар ирсэнийг харьялах шүүхэд хүргүүлэн гүйцэтгүүлэх арга хэмжээг авсан байна.

Гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны бусад чиг үүргийн хүрээнд:

Гадаад харилцааны асуудлаар хийх уулзалт, зөвлөгөөний бэлтгэлийг урьдчилан хангаж, удирдлагыг тухайн асуудлаарх шаардлагатай мэдээллээр ханган Ерөнхий шүүгч болон шүүгчдийг гадаадын зочид, төлөөлөгчидтэй уулзах үед орчуулагчаар ажилласан байна.

Гадаадын байгууллага, иргэдээс ирсэн албан бичиг, захидал, зохиол, бусад материалыг монгол хэлнээ хөрвүүлэн, Ерөнхий шүүгчид танилцуулсан, Ерөнхий шүүгчээс гадаадын байгууллага, иргэдэд явуулж буй албан бичиг, захидал, урилгыг англи хэл дээр хөрвүүлжээ.

Гадаад улс орны шүүхийн үйл ажиллагааны туршлага судалж, манай улс оронд нэвтрүүлж болох зүйлийг хэрэгжүүлэх талаар анхаарал хандуулан ажиллаж байна.

8. Дотоод аудитын алба:

2017 онд Дотоод аудитын алба нь байгууллагын оршин байгаа алдаа зөрчлийг тайлагнахаас илүүтэйгээр байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, гарч болох алдаанаас сэргийлэх, дотоод хяналтын сул талыг сайжруулахад чиглэн ажиллаа. 2014 онд шинээр байгуулагдсан уг алба нь Олон Улсын стандартын хүрээнд дотоод бүтэц чиг үүргийг боловсронгуй болгон төлөвшүүлэх, улмаар



байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирох аудитын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарч ажиллав.

Улсын Дээд шүүхийн Төсвийн ерөнхийлөн захирагч, Ерөнхий шүүгчийн 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 05 тоот захирамжаар “Эрсдэлд суурилсан Дотоод аудитын төлөвлөгөө”-г боловсруулан, Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргад танилцуулан батлуулж, уг төлөвлөгөөний дагуу ажиллаж, төлөвлөгдсөн ажлуудыг заасан хугацаанд хэрэгжүүлсэн.

Дотоод аудитаар удирдлагаас хэрэгжүүлж байгаа дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлыг шалгаж үнэлэн, байгууллагын үйл ажиллагаа нь холбогдох бодлого, горим, төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхийг авч үзсэн. Мөн эрсдэлийн удирдлага ба засаглалын бусад асуудлаар зөвлөмж өгч ажиллаа.

Дотоод аудитын алба нь аудитын ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу сар тутам төлөвлөж ажилласан.

2017 онд Монгол Улсын хэмжээнд Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланг Үндэсний Аудитын газар хүлээн авч хянан, дүгнэхээс 2 байгууллагад буюу Улсын Дээд шүүхийн 2016 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Ерөнхий аудитор “**ЗӨРЧИЛГҮЙ**” санал дүгнэлт урьдчилан өгч “**ИТГЭЛ**” үзүүлж ажилласан давуу талтай.

Шилэн дансны тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлэх” -ээр тусгасан.

Уг хуулийн дагуу 2017 оны батлагдсан төсөв, улирлын төсвийн гүйцэтгэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг шилэн дансанд байршуулж жигдрүүлснээр <http://shilendans.gov.mn/> сайтад мэдээлэл хуулийн хугацаанд тогтмол тавигдаж хэвшсэн ба нийт 156 мэдээллийг хугацаанд нь байршуулжээ.

Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 тоот тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу улирлын мэдээг Сангийн яаманд Дотоод аудитын албанаас хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Улсын Дээд шүүхийн “Дотоод аудитыг хэрэгжүүлэх эрсдэлд суурилсан төлөвлөгөөний дагуу” нийт 10 төрлийн аудитыг явуулсан.

Үүнд:



Нэг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар:

- Байгууллагын стратегийн зорилтыг хангахад захиргааны удирдлагын чиглэлээр;
- Ажилтнуудын сахилга, дэг журмыг сайжруулах, ажлын цаг ашиглалт, ажлын үр дүнд хяналт тавих чиглэлээр;
- Шүүхийн хүний нөөц, сургалтын чиглэлээр;
- Мэдээллийн технологийн чиглэлээр;
- Гадаад арга хэмжээний чиглэлээр;
- Шүүхийн аюулгүй байдлын чиглэлээр;
- Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийн чиглэлээр;

Хоёр. Төсөв, санхүүгийн хяналт, шалгалтын талаар:

- Санхүү, төсвийн холбогдолтой эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн чиглэлээр;
- Өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт хамгаалалтын чиглэлээр;
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиглэлээр тус тус аудит хийж тайлан бэлтгэсэн.

Гурав. Бусад ажлын талаар:

Шүүгчийн туслах болон нарийн бичгийн дарга нарт зориулан **“Жилийн үр дүнгийн гэрээний төсөл бичих, гэрээ байгуулах”** талаарх сургалтыг 2017 оны 1 дүгээр улиралд зохион байгуулсан.

Шүүхийн нийт захиргааны ажилтнуудын 2017 оны эхний хагас, бүтэн жилийн үр дүнгийн гэрээний төсөл, биелэлт, тайлагналд /тайланд/ анхаарах асуудлаар хүн нэг бүрт зөвлөгөөг өгч ажилласан.

“Шүүхийн захиргааны ажилтны ёс зүй” сэдвээр нийт захиргааны албан хаагчдад сургалт явуулсан.

2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан **“Хөрөнгө орлогын мэдүүлэг хэрхэн бэлтгэх”** сэдэвт сургалтанд хамрагдсан.

Тагнуулын ерөнхий газрын ажилтан **Б.Мөнхжаргалын “Төрийн байгууллагын цахим орон зайн нөхцөл байдал”** сэдвээр зохион байгуулсан сургалтанд бүрэн хамрагдан оролцсон.

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага болон **Монголын Дотоод аудиторчуудын хүрээлэнтэй** хамтран зохион байгуулсан **“Дотоод аудитын сургалт”**-нд бүрэн хамрагдаж амжилттай дүн үзүүлэн оролцож, гэрчилгээ авсан.



Төрийн захиргааны албан хаагчдын “**Үр дүнгийн гэрээ**”-ний төсөл биелэлт, илтгэх хуудсанд үнэлэлт дүгнэлт гаргаж ажиллаа.

Тус албанаас санаачлан шүүхийн залуучуудын зөвлөлтэй хамтран “**АМОС**” нийгэмд үйлчилдэг Төрийн бус байгууллагатай хамтран “**Халдварын бус гаралтай өвчлөлөөс сэргийлэх**” чиглэлээр сургалт явуулсан.

Шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн хорооны даргаар Албаны дарга сонгогдон ажилладаг.

9. Шүүхийн сургалт, семинарын чиглэлээр:

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнууд 2017 онд дараах сургалт, семинарыг зохион байгуулж, оролцлоо. Үүнд:

Эрүүгийн хэргийн танхим

Улсын Дээд шүүхээс 2017 оны 02 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд анхан болон давж заалдах шатны нийт шүүхүүдийн Ерөнхий шүүгч нарын дунд зохион байгуулсан “Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик” сэдэвт сургалт-уулзалт, ярилцлагад Танхимын тэргүүн **Т.Уранцэцэг**, шүүгч **Б.Батцэрэн**, **С.Батдэлгэр**, **Д.Ганзориг**, **Ч.Хосбаяр**, **Б.Цогт**, **Д.Эрдэнэбалсүрэн** нар оролцож зарим хууль тогтоомжийг шүүхийн практикт зөв хэрэглэх талаар сургалт явуулсан байна.

2017 оны 03 дугаар сарын 20-ны өдөр шүүгч **Б.Батцэрэн**, **Б.Цогт**, **Д.Эрдэнэбалсүрэн** нар “**Сургагч багш бэлтгэх**” сургалтад тус тус хамрагджээ.

Мөн Эрүүгийн хэргийн танхимаас 2017 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүдтэй “**Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**”, “**Зөрчлийн тухай**”, “**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай**”, “**Зөрчил шалган шийдвэрлэх тухай**” хуулийн төслүүдийн талаар уулзалт, ярилцлагад;

2017 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн Ерөнхий шүүгч нарт “**Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад анхаарах зарим асуудал**” сэдэвт уулзалт-ярилцлагад;

2017 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Танхимын тэргүүний туслах-ахлах шинжээч **Ц.Батзаяа**, шүүгчийн туслах-шинжээч **Б.Володя**, **С.Золбоо**, **Б.Наранжаргал**, **Н.Нямдаваа**, **Б.Содгэрэл**, **Г.Ууганбаатар**, **Ө.Учрал**, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-мэргэжилтэн **Т.Өлзийтүвшин** нар “**Эрүүгийн**



хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийг хэрэгжүүлэх” ажлын хэсгээс зохион байгуулсан сургалтанд;

2017 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Шүүхийн Ерөнхий зөвлөлтэй хамтран **“Шинээр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг шүүхэд хэрэглэх асуудал”** сэдэвт хэлэлцүүлэгт;

2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр **“Хууль буцаан хэрэглэх асуудал”, “Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”, “Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”**-иар эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн нийт шүүгч нарт тус тус сургалт зохион байгууллаа.

Мөн 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 04-ний өдрүүдэд Шүүхийн ерөнхий зөвлөл, Азийн хөгжлийн банктай хамтран **“Шүүхийн сургалтын чадавхыг бэхжүүлэх”** төслийн хүрээнд 3 ээлжээр зохион байгуулсан **“Эдийн засгийн гэмт хэрэг ба Монгол Улсын эрх зүйн зохицуулалт”** сэдэвт сургалтад шүүгч **Д.Эрдэнэбалсүрэн** “Эдийн засгийн гэмт хэрэг ба Монгол Улсын эрх зүйн зохицуулалт” сэдвээр, шүүгч **Б.Батцэрэн** “Татвар төлөхөөс зайлсхийх” гэмт хэрэг сэдвээр, шүүгч **Ч.Хосбаяр** “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” сэдвээр тус тус мэдээлэл өгч, сургалтыг удирдан явууллаа.

2017 оны 10 дугаар сарын 21, 28, 11 дүгээр сарын 04-ний өдрүүдэд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг шүүхэд хэрэглэх мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Дээд шүүх хамтран Тэрэлж дэхь Рэд рок ресорт сургалтын газар зохион байгуулсан **“Эрүүгийн эрх зүйн хууль тогтоомжийн шинэтгэл”** сэдэвт сургалтад Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Т.Уранцэцэг**, шүүгч **Б.Батцэрэн, Д.Ганзориг, Ч.Хосбаяр, Б.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн** нар “Хууль буцаан хэрэглэх, гэмт хэргийн хохирол ба хор уршиг, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх, хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах, хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх, хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ, өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хүний халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шинэлэг зохицуулалт ба зарим хүндрүүлэх нөхцөл байдал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдол, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч гэрч,



хохилогчийг хамгаалах, таслан сэргийлэх арга хэмжээ, хүсэлт гомдол гаргах, нотлох баримт, мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх журам, хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын талаар авах арга хэмжээ, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүхийн хэлэлцүүлэг явуулах дараалал тогтоох” зэрэг сэдвүүдээр хичээл зааж, хэлэлцүүлэг өрнүүлсэн байна. Тус сургалтанд эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн нийт **179** шүүгчид хамрагджээ.

2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн захиргааны ажилтнуудын холбоотой хамтран зохион байгуулсан “Шүүхийн захиргааны ажилтны ажил, мэргэжлийн ур чадварын улсын уралдаан”-нд тус танхимын шүүгчийн туслах-шинжээч Б.Наранжаргал оролцож, I шатанд тэргүүн байрт шалгарсан байна.

Иргэний хэргийн танхим

2017 оны 02 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд Улсын Дээд шүүхээс зохион байгуулсан “**Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик**” сэдэвт сургалт-уулзалт ярилцлагад Танхимын тэргүүн **Х.Сонинбаяр** “2016 онд Улсын хэмжээнд хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг, хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааны алдаа зөрчлийн тойм” сэдвээр, шүүгч **Г.Алтанчимэг** “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа” шүүгч **Ц.Амарсайхан** “Гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын хөрөнгөөс ногдох хэсгийг тогтоож буй шүүхийн практик, анхаарах зарим асуудал. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Гэр бүлийн тухай хуулийн төслийн /шинэчилсэн найруулга/ талаарх товч танилцуулга”, шүүгч **П.Золзаяа** “Худалдах худалдан авах гэрээний онцлог зохицуулалтууд, худалдагч, худалдан авагчийн эрх үүрэг” сэдвээр, шүүгч **Г.Цагаанцоож** “Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулсан үндэслэл, анхаарах асуудал” сэдвээр, шүүгч **Д.Цолмон** “Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийг дахин хянан шийдвэрлүүлэхээр буцаасан үндэслэл, анхаарах асуудал” сэдвээр тус тус сургалт явуулжээ.

2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Танхимын тэргүүн **Х.Сонинбаяр**, шүүгч **Г.Алтанчимэг**, **Ц.Амарсайхан**, **П.Золзаяа**, **Г.Цагаанцоож**, **Д.Цолмон**, **Х.Эрдэнэсүвд** нар Иргэний хэргийн танхимаас зохион байгуулсан “**Иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны практик**” уулзалт-ярилцлагын хүрээнд



Дархан-Уул, Сэлэнгэ, Булган аймгийн иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх, Сэлэнгэ аймгийн Сайхан, Мандал сум дахь сум дундын шүүхийн шүүгч нарт сургалт-ярилцлага;

2017 оны 5 дугаар сарын 22-27-ны өдрүүдэд Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхим Шүүхийн ерөнхий зөвлөл, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн "Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах" төсөлтэй хамтран иргэний эрх зүйн чиглэлээр зохион байгуулсан сургалтад;

Шүүгч **Г.Алтанчимэг** 2017 оны 4 дүгээр сарын 17-18, 27-28-ны Улсын Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Олон улсын Эрх зүйн хөгжлийн байгууллага хамтран Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл"-ийн ээлжит сургалтад **"Зээлдүүлэгчийн эрх"** сэдвээр;

2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас зохион байгуулсан "Иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны практик" уулзалт-ярилцлагын хүрээнд Дархан-Уул, Сэлэнгэ, Булган аймгийн иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх, Сэлэнгэ аймгийн Сайхан, Мандал сум дахь сум дундын шүүхийн шүүгч нарт **"Банкны зээлтэй холбоотой маргааныг шийдвэрлэх, анхаарах асуудал"** сэдвээр;

шүүгч **Ц.Амарсайхан** 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар, Орхон, Дархан, Төв аймгийн шүүхийн шүүгч нарт **"Гэр бүлийн маргаан, гэр бүлийн хүчирхийлэлтэй иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа"**, **"Гэр бүлийн холбогдолтой иргэний маргааныг үр нөлөөтэй хянан шийдвэрлэх арга зам"** сэдвээр;

шүүгч **П.Золзаяа** 2017 оны 03 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд Монголын хуульчдын холбооноос зохион байгуулсан уулзалт-ярилцлагын хүрээнд **"Хөдөлмөрийн харилцаанаас үүссэн маргаанд хэрэглэх хууль тогтоомж"** сэдвээр;

2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн байранд Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нарт **"Иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны практик"** уулзалт-ярилцлагын хөтөлбөрийн хүрээнд **"Гэр бүлийн хөрөнгийн эрх зүйн маргаантай шүүхийн практик анхаарах асуудал"**, **"Төсөөтэй гэрээг ялгах /хөдөлмөрийн болон хөлсөөр ажиллах гэрээ/, Иргэний хууль тайлбарлах, фрайнчайз, мерчендайзын гэрээний зохицуулах онцлог ялгаа"** сэдвээр;



шүүгч **Д.Цолмон** 2017 оны 4 дүгээр сарын 17-18, 27-28-ны өдрүүдэд Улсын Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Олон улсын Эрх зүйн хөгжлийн байгууллага хамтран Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл"-ийн ээлжит сургалтад **"Оюуны өмч"** гэсэн сэдвээр;

2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас зохион байгуулсан **"Иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны практик"** сэдвээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчтэй хийх уулзалт-ярилцлага"-ын хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул, Сэлэнгэ, Булган аймгийн Иргэний хэргийн анхан болон давж заалдах, Сэлэнгэ аймгийн Сайхан, Мандал сум дахь сум дундын шүүгч нарт Иргэний хуулийн 200, 202 дугаар зүйл. **/Гэрээний стандарт нөхцөл, түүнийг практикт хэрэглэх нь/** сэдвээр 2017 оны 5 дугаар сард Монголын өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулсан уулзалт-ярилцлагын хүрээнд **"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт гаргах өмгөөлөгчдийн ажиллагаа"** сэдвээр;

2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Иргэний хэргийн танхимаас зохион байгуулсан **"Иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны практик"** уулзалт-ярилцлагын хүрээнд Дархан-Уул, Сэлэнгэ, Булган аймгийн иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх, Сэлэнгэ аймгийн Сайхан, Мандал сум дахь сум дундын шүүхийн шүүгч нарт **"Иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны практик"** уулзалт-ярилцлагын хөтөлбөрийн хүрээнд **"Гэрээг цуцлах, гэрээнээс татгалзах", "Орон сууц худалдах-худалдан авах гэрээ"** сэдвээр;

2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас зохион байгуулсан **"Иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны практик"** сэдвээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчтэй хийх уулзалт-ярилцлага"-ын хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул, Сэлэнгэ, Булган аймгийн иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх, Сэлэнгэ аймгийн Сайхан, Мандал сум дахь сум дундын шүүхийн шүүгч нарт **"Иргэний хуулийн 89-98, 98-114 дүгээр зүйл /Эзэмшил үүсэх, өөрчлөх, дуусгавар болох", "Өмчлөх эрх үүсэх, өөрчлөх, дуусгавар болох нийтлэг болон ялгаатай тал"** сэдвээр;

2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Баяндөхөм сургалтын төвд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан **"Эвлэрүүлэн зуучлагч"** нарын сургалтад **"Үүргийн гүйцэтгэлийг хангах арга"** сэдвээр;

шүүгч **Б.Ундрах** 2017 оны 5 дугаар сард Монголын өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулсан уулзалт-ярилцлагын хүрээнд **"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны талаар"** сэдвээр;



2017 оны 5 дугаар сард GIZ болон Европын хөгжлийн банкнаас зохион байгуулсан сарын хугацаатай сургалтанд **“Худалдааны эрх зүй”** сэдвээр;

2017 оны 6 дугаар сарын 03-ны өдөр Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс зохион байгуулсан “Шинээр томилогдсон шүүгч нарын сургалт” сэдэвт сургалтанд **“Анхан шатны шүүх хуралдаан”** сэдвээр;

2017 оны 6 дугаар сарын 03-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан **“Шинээр томилогдсон шүүгч нарын сургалт”** сэдэвт сургалтад **“Эрх зүйн маргаан, иргэний хэрэг үүсгэх үндэслэл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчим, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны төрөл”** сэдвээр;

2017 оны 8 дугаар сардын 11-14-ний өдрүүдэд Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан сургалтад **“Иргэний хууль хэрэглэх, бодлого бодох аргачлал”** сэдвээр;

2017 оны 9 дүгээр сарын 26-нд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан **“Эвлэрүүлэн зуучлал ба Иргэний хуулийн холбогдох зохицуулалт”** сэдвээр;

2017 оны 9 дүгээр сарын 15-17, 9 дүгээр сарын 19-21, 10 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд Иргэний эрх зүйн сургалтын хүрээнд анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нарт;

2017 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр шинэ шүүгч нарын сургалтаар **“Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах” “Хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаа”, “Шүүхийн шийдвэр боловсруулах”** сэдвээр;

2017 оны 10 дугаар сард Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад **“Иргэний хуулийн 243, 286 дугаар зүйл”** сэдвээр;

2017 оны 9, 10, 11 дүгээр сард Монголын өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулсан уулзалт-ярилцлагын хүрээнд **“Гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг шийдвэрлэхтэй холбоотой зарим асуудал”** сэдвээр;

2017 оны 10 дугаар сарын 09-ний өдөр Эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх сургалтанд **“Эвлэрлийн гэрээ боловсруулах”** сэдвээр;

шүүгч **Г.Цагаанцоож** 2017 оны 5 дугаар сард Монголын өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулсан уулзалт-ярилцлагын хүрээнд **“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтыг үнэлэх ажиллагаа”** сэдвээр тус тус хичээл заажээ.

шүүгч **Х.Эрдэнэсувд** 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас зохион байгуулсан “Иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны практик” сэдвээр анхан болон давж заалдах шатны шүүхийн



шүүгчтэй хийх уулзалт-ярилцлага"-ын хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул, Сэлэнгэ, Булган аймгийн Иргэний хэргийн анхан болон давж заалдах, Сэлэнгэ аймгийн Сайхан, Мандал сум дахь сум дундын шүүгч нарт "2016 он, 2017 оны эхний улирлын байдлаар Дархан, Сэлэнгийн иргэний хэргийн шүүхээс Улсын Дээд шүүхээр хянагдсан хэргийг маргааны төрлөөр нь ангилан судалгаа хийж, статистик тоо баримтын танилцуулга хийжээ.

Шүүгч **Д.Цолмон** 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн шүүх байгуулагдсаны 90 жилийн ойд зориулсан **"Иргэний эрх зүйн онол, практикийн уялдаа"** сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд **"Интернетийн орчин дахь зохиогчийн эрхийн хамгаалалт"** сэдвээр илтгэл тавьж оролцжээ.

Шүүгч **Ц.Амарсайхан, Г.Цагаанцоож, Б.Ундрах** нар 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөл, Олон улсын Эрх зүйн хөгжлийн байгууллага хамтран зохиосон "Монгол Улсад гэр бүлийн маргаан, гэр бүлийн хүчирхийлэлтэй иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, цаашдын төлөв" сэдэвт;

шүүгч **Ц.Амарсайхан** 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөл, Олон улсын Эрх зүйн хөгжлийн байгууллага хамтран зохиосон **"Монгол Улсад гэр бүлийн маргаан, гэр бүлийн хүчирхийлэлтэй иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, цаашдын төлөв"** сэдэвт;

2017 оны 3 дугаар сар болон 6 дугаар сарын 21-ний өдрүүдэд Хөдөлмөр нийгмийн халамжийн яаманд **"Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл боловсруулах"** сэдэвт;

2017 оны 5 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд Хууль зүйн үндэсний хүрээлэнд **"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах"** ажлын хэсгийн хэлэлцүүлэгт;

шүүгч **Г.Цагаанцоож** Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан уулзалт-ярилцлагын хүрээнд **"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай"** хэлэлцүүлэгт **"Хяналтын шатны шүүхийн чиг үүргийг боловсронгуй болгох"** сэдэвт хэлэлцүүлэгт оролцож,

шүүгч **Б.Ундрах, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд** нар Хуульчдын холбоотой хамтран Улсын Дээд шүүхийн хуульчийн гэрчилгээтэй ажилтнуудад 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хичээл заажээ.

Захиргааны хэргийн танхим

Улсын Дээд шүүхээс 2017 оны 02 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд анхан болон давж заалдах шатны нийт шүүхүүдийн Ерөнхий шүүгч нарын дунд зохион



байгуулсан “Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик” сэдэвт сургалт-уулзалт, ярилцлагад Танхимын тэргүүн **М.Батсуурь** “Захиргааны хэргийн шүүхийн шүүн таслах ажиллагааны тойм, Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн шаардлагын төрлүүд”, шүүгч **Л.Атарцэцэг** “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарч буй алдаа, зөрчлийн тойм”, шүүгч **Д.Мөнхтуяа**: “Шүүхээс хууль тайлбарлан хэрэглэхэд анхаарах зарим асуудал”, шүүгч **Г.Банзрагч**: “Захиргааны гэрээний зохицуулалт”, шүүгч **П.Соёл-Эрдэнэ** “Төрийн албаны маргаан” сэдвээр;

Захиргааны хэргийн танхимын тэргүүн **М.Батсуурь** 2017 оны 4 дүгээр сарын 19, 29-ний өдрүүдэд Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл 2-р шат “**Өрсөлдөөний эрх зүй**” сэдвээр;

шүүгч **Д.Мөнхтуяа** 2017 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарт “**Хууль тайлбарлаж хэрэглэх, үндэслэл зарчим**” сэдвээр;

2017 оны 4 дүгээр сарын 11, 12, 21, 22-ны өдрүүдэд Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл 2 дугаар шат “**Ашигт малтмалын эрх зүй**” сэдвээр;

2017 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч, шүүгч нарт “**Захиргааны хэргийн шүүхийн Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа**” сэдвээр;

2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр Авлигатай тэмцэх газрын ажилчдад “**Захиргааны ерөнхий хууль, хэрэглээ, шүүхийн практик**”, “**Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаан, хууль хэрэглээнд анхаарах асуудал**” сэдвээр;

2017 оны 9 дүгээр сарын 14-ны өдрүүдэд Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төсөл 2-р шат 3 дахь ээлжийн “**Өрсөлдөөний эрх зүй**” сэдвээр;

2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс 12 дугаар сарын 01, 12 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарт “**Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хангах, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах**” сэдвээр;

шүүгч Г.Банзрагч “**Захиргааны гэрээний маргааны онцлог**” сэдвээр;

шүүгч П.Соёл-Эрдэнэ “**Төрийн албаны маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн практик**” сэдвээр;

2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс 12 дугаар сарын 01, 12 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарт “**Улсын бүртгэлийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа**” сэдвээр;



Танхимын тэргүүн М.Батсуурь 2017 оны 12 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарт **“Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хангах, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах”** сэдвээр,

шүүгч П.Соёл-Эрдэнэ 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдөр, 12 дугаар сарын 06-ны өдрөөс 12 дугаар сарын 08-ны өдрүүдэд Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нарт **“Төрийн албаны маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн практик”** сэдэвээр тус тус хичээл заажээ.

Шүүгч **Д.Мөнхтуяа** 2017 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр IDLO-ийн мэргэжилтэнтэй **“Худалдааны эрх зүйн чиглэлээр шүүгчдийг сургах төслийн талаар”** сэдэвт;

шүүгч **Х.Батсүрэн, Ч.Тунгалаг** нар Улсын Дээд шүүхээс 2017 оны 02 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд анхан болон давж заалдах шатны нийт шүүхүүдийн Ерөнхий шүүгч нарын дунд зохион байгуулсан **“Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик”** сэдэвт;

Шүүгч **Д.Мөнхтуяа** 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд зохион байгуулагдсан **“Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах нь”** судалгааны тайлан хэлэлцүүлэгт;

2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан **“Шүүхийн шинэтгэлийн хэрэгжилтийн үр дүн”** хэлэлцүүлэгт;

2017 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Төрийн албаны зөвлөлөөс хамтран зохион байгуулсан **“Төрийн албаны эрх зүйн шинэтгэл ба тулгамдсан асуудал”** сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд;

шүүгч **Г.Банзрагч, П.Соёл-Эрдэнэ** нар 2017 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан **“Шүүгчийн ёс зүй сургагч багш”** сэдэвт;

2017 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан **“Захиргааны хэргийн шүүхийн Зөрчил шалган шалган шийдвэрлэх ажиллагаа”** сэдэвт,

шүүгч **Х.Батсүрэн** 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр **МҮОНТ**-ийн **“Эрх зүйн хөтөч”** нэвтрүүлэгт оролцож, **“Нийгмийн даатгалтай холбоотой маргаан”** сэдэвт,

шүүгч **Б.Мөнхтуяа** Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн ажлын хэсгээс зохион байгуулсан уулзалтанд оролцсон;



шүүгч П.Соёл-Эрдэнэ 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр **“Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”** хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт оролцсон;

2017 оны 11 дүгээр сарын 17-нд Улсын дээд шүүхийн захиргааны ажилчдад **“Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах шаардлагын төрлүүд”** сэдэвт сургалт-уулзалт, ярилцлагад тус тус оролцжээ.

2017 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Хуульчдын холбооноос зохион байгуулсан **“Хуульчдын форум”** хэлэлцүүлэгт;

Шүүгч **Г.Банзрагч, П.Соёл-Эрдэнэ** нар 2017 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас зохион байгуулсан **“Өрсөлдөөний тухай хууль”**-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт;

шүүгч **Л.Атарцэцэг, Г.Банзрагч, П.Соёл-Эрдэнэ** нар 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр **“Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”** хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт тус тус оролцжээ.

Мөн Танхимын тэргүүн **М.Батсуурь** 2017 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Шүүхийн ерөнхий зөвлөл **“Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ба шүүх эрх мэдэл”** сэдэвт хэлэлцүүлэгт паналистаар;

2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөл, Нээлттэй нийгэм форум хамтран зохион байгуулсан **“Шүүгчийн хараат бус байдал ба олон нийтийн хяналт сэдэвт”** хэлэлцүүлэгт **“Шүүхийн хараат бус байдлыг хангахад тулгарч буй сорил”** сэдвээр илтгэл,

Танхимын тэргүүн **М.Батсуурь** Гадаад хэргийн яам, Нээлттэй нийгэм форум хамтран зохион байгуулсан Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн асуудлаарх Олон Улсын хурал: Монгол Улсын жишээ /Монгол Улсын Үндсэн хууль: 25 жилийн туршлага, сургамж/ хуралд 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдөр **“Монгол Улсад хүний эрхийг хамгаалахад шүүх эрх мэдлийн гүйцэтгэж буй үүрэг ба тулгамдсан асуудал”** сэдэвт илтгэл;

Тамгын газар

Тамгын газар нь 2017 оны 02 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд анхан болон давж заалдах шатны нийт шүүхүүдийн Ерөнхий шүүгч нарт **“Шүүн таслах ажиллагаа, шүүхийн шийдвэрийн талаарх практик”** сэдэвт сургалт-уулзалт, ярилцлага;

2017 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Төрийн мэдээлэл холбооны газартай хамтран **“Төрийн байгууллагуудын цахим орчны нөхцөл байдал, халдлагуудын**



жишээ, цахим хуудас, цахим шуудангийн аюулгүй байдал” сэдвээр, шүүхийн ёс зүйн хороотой хамтран “Шүүхийн захиргааны ажилтны ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт;

2017 оны 6 дугаар сард Говь-Алтай, Баянхонгор, Булган, Орхон аймгийн сумдын Засаг дарга, хуулийн байгууллагын ажилтнууд, төрийн албан хаагч нарт Шүүхийн практик судлалын хэлтсийн дарга **Ч.Нямсүрэн**, Гэмт хэргийн шүүн таслах ажиллагаа хариуцсан зөвлөх **С.Нямжав** нар “Эрүүгийн хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн хэрэгжилт сэдэвт;

2017 оны 11 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд Монголын Хуульчдын холбоотой хамтран хуульчийн гэрчилгээ бүхий захиргааны ажилтнуудад 4 багц цаг олгох сургалтанд шүүгч **Г.Банзрагч, Б.Батцэрэн, Д.Ганзориг, П.Соёл-Эрдэнэ, Б.Ундрах, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд**, Тамгын газрын дарга **Ж.Наранпүрэв** нар “Өв залгамжлал, шүүхийн практик”, “Гэм хорын эрх зүй, эдийн бус гэм хор”, “Хөдөлмөрийн хуулийн хэрэглээ, анхаарах асуудал”, “Захиргааны эрх зүйн үйл ажиллагааны хэм хэмжээ”, “Үндсэн хуулийн эрх зүй”, “Хуульчийн ёс зүй”, “Эрүүгийн хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”, “Үндсэн хуулийн хөгжлийн чиг хандлага”, “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн шаардлагын төрлүүд” сэдэвт сургалт тус тус зохион байгууллаа.

Эрхэм шүүгч, ажилтнууд аа!

Улирч буй 2017 онд бид амжилт бүтээл арвин байлаа. Ирж буй 2018 онд бид шинээр батлагдсан хуулиудыг хэрэгжүүлэх, шүүхийн шинэчлэлийг шинэ шатанд гарган зохион байгуулах, шүүн таслах болон шүүхийн захиргааны удирдлагын шинэ бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж ажиллах нэн хариуцлагатай жил байх болно.

Тиймээс бид ирж буй жилд нөр их ажлыг амжилттайгаар гүйцэлдүүлэх шаардлагатай бөгөөд үүнд та бүхнийг идэвхи санаачлага, итгэл зүтгэл, үр бүтээл гарган ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэндээ шинэ жилийн баярын мэнд дэвшүүлж, аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе.

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР**

2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр